

**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН
2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТОВЧ ТАЙЛАН**

2022.06.20

Улаанбаатар хот

“Автотээврийн үндэсний төв” нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан үйлдвэрийн газрын дүрэм, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай 2022 онд байгуулсан Контрактын гэрээ, Зам, тээврийн хөгжлийн яамтай 2022 онд байгуулсан “Ажил үйлчилгээ хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ” түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үйлдвэрийн газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2022 оны эхний хагас жилд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.

НЭГ. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

1.1 Дээд газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаанаас тус үйлдвэрийн газарт нийт 28 үүрэг даалгавар өгөгдсөн. Үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн гаргаж, 7 хоног бүр ЗТХЯ-ны ТЗУГ-т хүргүүлж байна. ЗТХЯ-ны ХШҮДАГ-аас 2022.06.20-ны өдрийн байдлаар 25 үүрэг даалгаврыг 100% хэрэгжсэнд тооцож, хяналтаас хассан бөгөөд хэрэгжилтийн шатанд-2, удааширсан 1 үүрэг байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар дээд газарт нийт 51 тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг гаргаж, тайлагнан ажилласан. Үүнд

1. Монгол улсын хууль-1
2. Ерөнхийлөгчийн зарлиг-1
3. Засгийн газрын тогтоол-1
4. Засгийн газрын албан даалгавар -1
5. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-3
6. Сайдын тушаал -36
7. Сайдын албан даалгавар -4
8. ТӨБЗГ-ын тогтоол -2
9. ТӨБЗГ-ын албан даалгавар -1
10. Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар -1

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 259 дүгээр тушаалаар батлагдсан “Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, харьяа байгууллагын тогтмол гаргах тайлан мэдээллийн нэр, төрөл, хугацаа”-ны дагуу 2022 оны эхний хагас жилийн дараах тайлан, мэдээнүүдийг нэгтгэн боловсруулж, ЗТХЯ-нд хугацаанд нь хүргүүлж ажилласан. Тухайлбал:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Албан даалгавар, Хуралдааны тэмдэглэлээр тус үйлдвэрийн газарт өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2022 оны I улирлын байдлаар гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2022.03.22-ний өдрийн 1/365, эхний хагас жилийн байдлаар 2022.06.07-ний өдрийн 1/772 тоот албан бичгээр тус тус хүргүүлж, тайлагнасан.
2. Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдаанаас тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2022 оны I улирлын байдлаар гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2022.03.28-ны өдрийн 1/394, эхний хагас жилийн байдлаар 2022.06.15-ны өдрийн 1/807 тоот албан бичгээр тус тус хүргүүлж, тайлагнасан.
3. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/125, 2021 оны 02 дугаар албан даалгавраар тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2022

- оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2022.06.13-ны өдрийн 1/798 тоот албан бичгээр хүргүүлж, тайлагнасан.
4. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01 дүгээр албан даалгавраар тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2022.06.13-ны өдрийн 1/797 тоот албан бичгээр хүргүүлж, тайлагнасан.
 5. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021.09.15-ны өдрийн 07 дугаар албан даалгавраар тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2022 оны 01 дүгээр улирлын байдлаар гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2022.03.22-ны өдрийн 1/366, эхний хагас жилийн байдлаар 2022.06.13-ний өдрийн 1/798 тоот албан бичгээр тус тус хүргүүлж, тайлагнасан.
 6. Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар тус үйлдвэрийн газарт өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2022 оны I улирлын байдлаар гаргаж, 2022.03.24-ны өдрийн 1/380, эхний хагас жилийн байдлаар 2022.06.08-ны өдрийн 1/781 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ХШҮДАГ-т тус тус хүргүүлж тайлагнасан.
 7. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны I улирлын байдлаар нэгтгэн гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2022.03.24-ны өдрийн 1/378, эхний хагас жилийн байдлаар 2022.06.10-ны өдрийн 1/793 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ХШҮДАГ-т тус тус хүргүүлж тайлагнасан.
 8. “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлтийг 2022 оны I улирлын байдлаар нэгтгэн гаргаж, ЗТХЯ-ны АТБХЗГ-т 2022.03.24-ны өдрийн 1/379, эхний хагас жилийн байдлаар 2022.06.10-ны өдрийн 1/791 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ХШҮДАГ-т тус тус хүргүүлж тайлагнасан.
 9. “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн биелэлтийг 2022 оны I улирлын байдлаар нэгтгэн гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2021.03.29-ны өдрийн 1/407, эхний хагас жилийн байдлаар 2022.06.13-ны өдрийн 1/822 тоот албан бичгээр тус тус хүргүүлж тайлагнасан.

Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд автотээврийн чиглэлээр тусгах саналыг боловсруулж, ЗТХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газарт 2022.01.13-ний өдрийн 1/90 тоот албан бичгээр хүргүүлсэн.

ТӨБЗГ-тай үйлдвэрийн газрын захирлын 2021 онд байгуулсан Контрактын хэрэгжилтийг гаргаж, ТӨБЗГ-т 2022.04.12-ны өдрийн 2/468 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тайлагнасан. ТӨБЗГ-ын 2022.05.03-ны өдрийн 143 дугаар тогтоолоор “АТҮТ” ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон захирал Б.Гүрсоронзонтой байгуулсан контрактын биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсэн.

ТӨБЗГ-ын 2021.02.26-ны өдрийн А-1/354 дүгээр албан даалгавраар тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2022 оны 1-р улирлын байдлаар гаргаж, ТӨБЗГ-т 2022.03.29-ний өдрийн 1/408 тоот албан бичгээр хүргүүлж, тайлагнасан. Эхний хагас жилийн байдлаар гаргаж, 2022.06.30-ны дотор хүргүүлнэ.

1.2. Үйлдвэрийн газрын захирлын тушаал, шийдвэрийг хангах ажлын хүрээнд:

ТӨБЗГ-ын 2021 оны 420, 534 дүгээр тогтоол тус тус батлагдсантай холбогдуулан үйлдвэрийн газрын Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, Захирлын 2022.03.14-ний өдрийн А/71 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулсан. Тайлант хугацаанд Захирлын зөвлөл 1 удаа хуралдаж, 1 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулахаар ажиллаж байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар үйлдвэрийн газрын шуурхай зөвлөгөөн 11 удаа хуралдаж, Захирал, дэд захирлуудаас нэгжийн дарга нарт нийт 112 үүрэг даалгавар өгсөн. Шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврыг боловсруулан гаргаж, хэлтсийн дарга болон шуурхай

удирдсан удирдлагад хянуулж, танилцуулан нэгжийн дарга болон холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлж, биелэлтийг нэгтгэн ХШДАА-нд хүргүүлэн ажиллаж байна.

Мөн шуурхай зөвлөгөөнөөс тус хэлтэст өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт болон Шуурхайн зөвлөгөөнд ЗСХНХ-ээс танилцуулах танилцуулгыг бэлтгэн шуурхай зөвлөгөөнд удирдлагуудад танилцуулж байна. 2022.06.20-ны өдрийн байдлаар бүрэн хэрэгжсэн 67, хэрэгжилтийн шатанд 11, удааширсан 34 үүрэг даалгавар байна. Үүргийн биелэлтийг нэгж тус бүрээр харуулбал:

1.3. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт

Байгууллагын үйл ажиллагааг оновчтой төлөвлөх ажлын хүрээнд тайлант хугацаанд дараах төлөвлөгөөг боловсруулж, батлуулан ажилласан. Үүнд:

1. Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө
2. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын ажилтнуудын 2022 оны сургалтын төлөвлөгөө
3. ЗТХЯ-наас “АТҮТ” ТӨҮГ-тай 2022 онд байгуулах Ажил үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөө
4. ЗТХЯ-ны Улсын ахлах байцаагчийн “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тухай” 2022.02.15-ны өдрийн 38-07-069/006 тоот албан шаардлагыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө
5. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ -ын 2022 оны авлигын эсрэг төлөвлөгөө,
6. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар зөвлөлийн 2021-2022 онд хийх ажлын ерөнхий төлөвлөгөө

1.4 Дотоод үйл ажиллагааны зохион байгуулалтын талаар:



Удирдах ажилтны зөвлөгөөнийг 2022.03.03-04-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулсан бөгөөд нийт 74 удирдах ажилтан тус зөвлөгөөнд оролцсон.

Тус зөвлөгөөнөөр бүтцийн нэгжүүдийн дарга нарын тайланг сонсон, цаашид хийж гүйцэтгэх ажлын талаар үүрэг даалгавар өгч, санал солилцсон.

Үйлдвэрийн газрын дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран үйлдвэрчний хороонд бүртгэлтэй 82 эмэгтэй гишүүддээ олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах буюу МАРТ-8 өдрийг тохиолдуулан “Улаан цэцэг” УСК үзүүлэх ажлыг зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар мод тарих үндэсний өдрийг жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн “Бямба” гариг болгон зарласан бөгөөд үйлдвэрийн газрын захирлын 2022.05.05-ны өдөр баталсан хөтөлбөрийн дагуу 1 ажилтан 1 мод уриалгыг дэвшүүлэн 800 мод тарьсан.

Үйлдвэрийн газрын ажилтнууд “Эрүүл чийрэг ажилтан” ууланд алхах удирдамжийн хүрээнд Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтэс зохион байгуулан 2022.05.14-ний өдөр Чингэлтэй хайрханд, Ачаа тээврийн хэлтэс зохион байгуулан 2022.06.06-ны өдөр Богд ууланд тус тус алхалт хийсэн.

Төмөр зам, Далайн тээвэр, ЗТХЯ зэрэг Зам, тээврийн салбарын залуучуудын байгууллагуудын Залуучуудын зөвлөлөөс “Асуудалд шийдэл байдаг” уриан дор Зам, тээврийн салбарын залуучуудын зөвлөгөөнийг 2022.06.03-ны өдөр Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулсан. Уг зөвлөгөөнөөр “Автотээврийн салбарын цахим хөгжил”, “Төмөр замын бүтээн байгуулалт ба залуучууд”, “Автозамын шинэчлэл хөгжил”, “Иргэний нисэхийн салбарын хүний нөөцийн бодлого”, “Залуусын хөгжил ба цахим шилжилт” сэдвүүдээр хэлэлцэж гарсан шийдэл дүгнэлтээ Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга гардуулж өгсөн.

Үйлдвэрийн газрын захирлын баталсан удирдамжийн дагуу орон нутагт албан томилолтоор ажиллаж байгаа ажилтнуудын бүртгэлийг хөтөлж, томилолтын хуудас олгож ажилласан. Үүнд: 2022.06.20-ны өдрийн байдлаар нийт 46 удаагийн томилолтын хуудас олгосон.

Албан томилолтын удирдамжийн дагуу СЭЗХ болон ХШДАА-ны холбогдох ажилтнуудтай хамтран томилолтыг дотоод журамд заасан хугацаанд хаалгах ажлыг тухай бүрт нь зохион байгуулан ажиллаж байна. Мөн албан томилолтоор орон нутагт ажилласан 54 ажилтанд томилолтоор ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсөн.

1.5. Ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, төрөл бүрийн спортын тэмцээнд оролцуулах ажлын хүрээнд:

Тус үйлдвэрийн газрын ажилтан, албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдгээрийн бие бялдрыг өв тэгш хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилах сэргийлэх зорилгоор Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуультай хамтран ажиллах ТГ-22/05 тоот гэрээг 2022.01.06–2022.12.29-ний өдрийг дуустал хугацаатай байгуулж, ажилтнуудыг зааланд хамруулж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж байна.

1.6. Хүний нөөцийн бүрдүүлэлтийн хүрээнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 420 дугаар тогтоолоор “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Үүнд:

Захирал-1, Дэд захирал-4, 1 алба, 8 хэлтэс, 4 тасаг, Улаанбаатар хот дахь Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын 1 төв, Зорчигч тээврийн 2 төв, Техникийн хяналтын үзлэгийн 3 төв, аймгийн автотээврийн 21 төв болон Замын-Үүд, Цогтцэций салбар болно. Орон тооны дээд хязгаарыг 819 ажилтан, албан хаагчтай байхаар тогтоосон

2022.06.20-ний өдрийн байдлаар 1 алба, 8 хэлтэс, 4 тасаг, 1 төвд 288 орон тоо баталсанаас 267 ажилтан, албан хаагч, Улаанбаатар хот дахь Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв, Зорчигч тээврийн 2 төв, Техникийн хяналтын үзлэгийн 3 төвд 187 орон тоо баталсанаас 157 ажилтан, албан хаагч, аймгийн автотээврийн 21 төв, Замын-Үүд, Цогтцэций салбарт нийт 320 орон тоо баталсанаас 307 ажилтан, албан хаагч тус тус томилогдон ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд үйлдвэрийн газарт нийт 731 ажилтан, албан хаагч ажиллаж байна. Үйлдвэрийн газрын хэмжээнд нийт 50 гэрээт ажилтан /төвд 7, орон нутагт 43 ажиллаж байна.

Үйлдвэрийн газрын хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааны ерөнхий чиглэлийн дараах дүрэм журмуудыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэх зорилгоор захирлын тушаалаар батлан, хүний нөөцийн удирдлагын зохион байгуулалт, албан тушаал, ажлын зохион байгуулалт, албан тушаалд тавигдах шаардлага, хүний нөөцийг бүрдүүлэх, шилж сонгон авах, үр дүнтэй ашиглах, тогтвор суурьшилтай ажиллуулах, хүний нөөцийн сургалт, хөгжил, ажиллах нөхцөл, баталгаа, гүйцэтгэлийн удирдлагын зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. “Хөдөлмөрийн дотоод журам” - 2022.01.03-ны өдрийн А/01 дугаар тушаал
2. “Ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” - 2015.09.28-ны өдрийн А/209 дүгээр тушаал
3. “Ажилтны сургалтын ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр” - 2015.09.28-ны өдрийн а/208 дугаар тушаал
4. “Ёс зүйн дүрэм” - 2021.09.13-ны өдрийн А/207 дугаар тушаал
5. “Ажилтныг шагнаж урамшуулах түүнийг олгох журам” - 2015.08.31-ний өдрийн А/177 дугаар тушаал
6. “Нэгжийн удирдлага, ажилтны үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх журам” - 2018.11.07-ны өдрийн А/334 дүгээр тушаал
7. “Мэргэжил, ур чадвар түвшин тогтоох журам” - 2015.10.06-ны өдрийн А/217 дугаар тушаал
8. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх журам” - 2017.09.11-ний өдрийн А/276 дугаар тушаал
9. “Автотээврийн тээврийн үндэсний төвийн ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам” - 2018.10.08-ны өдрийн А/303 дугаар тушаал,
10. “Автотээврийн тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг” 2019.12.30-ны өдрийн А/385 дугаар тушаал.

Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, үйлдвэрийн газрын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ЗСХНХ-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 оны эхний хагас жилд үйлдвэрийн газрын хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохицуулан зохион байгуулах дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Үндэсний аудитын газраас Үйлдвэрийн газрын 2020-2021 оны үйл ажиллагаанд аудит хийсэн, Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2022.02.09-ний өдрийн СХЭУГ-01 дугаарын “Автотээврийн тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалттай холбогдуулан үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийн 1 алба, 8 хэлтэс, 6 тасаг, 1 төв, Улаанбаатар хот дахь Зорчигч тээврийн 2 төв, Техникийн хяналтын үзлэгийн 3 төв болон аймгийн автотээврийн 21 төв, Замын-Үүд, Цогтцэций салбарын нийт ажилтнуудын бүрэлдэхүүн хөдөлгөөн тайлан, ажилтны нийгмийн хамгаалал, сургалт хөгжүүлэлт, мэргэжил боловсрол, туршлагатай холбогдох судалгааг гаргаж тайлагнаж ажилласан.

Үйлдвэрийн газрын төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичгийн бүртгэл, шилжилт, хадгалалт, нууцлалтад хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд аль нэг байгууллагаас төрийн болон албаны нууцад хамаарах 25 албан албан бичиг ирж, 9 албан бичгийн хариуг албан бичгээр хүргүүлж, 16 албан бичгийг холбогдох дүрэм журмын дагуу шийдвэрлэсэн.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сар бүрийн 08-ны өдрийн дотор нийтэд ил тод хүргэх шилэн дансны мэдээллийн бүрэлдэхүүн хэсэг хүний нөөцтэй холбогдох мэдээллийг сар бүр 5 удаа хуулийн хугацаанд мэдээлсэн.

Ажилд шинээр томилогдсон, ажлаас чөлөөлөгдсөн ажилтныг тухай бүр нь үйлдвэрийн газрын цахим дотоод сүлжээний програмд бүртгэх болон хасч ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжилтыг хийж холбогдох баримт бичиг, мэдээллүүдийг боловсруулан ажиллаж байна. Мөн Захиргааны чөлөөтэй, өвчтэй, томилолттой, ээлжийн амралттай ажилчдыг мэдээллийг тухай бүр цахим дотоод сүлжээний цагийн бүртгэлд бүртгэж ажилласан.

1.7 Ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шагнаж урамшуулах, болон сахилга хариуцлагыг дээшлүүлэх асуудлын хүрээнд:

Ажилтнуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, “Хөдөлмөрийн тухай хууль”, үйлдвэрийн газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу судлан хянаж, удирдлагад танилцуулж тухай бүр шийдвэрлүүлэн ажиллаж байна. Тухайлбал:

Гэр бүлд нь шинээр хүүхэд төрсөн 23 ажилтанд 3.110.000 /гурван сая нэг зуун арван мянган/ төгрөгийн тэтгэмж, шинээр гэр бүлээ батлуулсан 5 ажилтанд 1000,000 /нэг сая/ төгрөгийн тэтгэмж олгосон.

-Ар гэрт нь гачигдал тохиолдсон 12 ажилтанд 2.550.000 /хоёр сая таван зуун тавин мянган/ төгрөгийн тусламж олгосон.

-Ахмадын хороонд бүртгэлтэй 7 ахмадад 1.400.000 /нэг сая дөрвөн зуун мянга/ төгрөгийн тусламж олгосон.

- 1 ажилтанд эмчилгээний зардалд 1.115.000 /нэг сая нэг зуун арван таван мянга/ төгрөгийн тусламж олгосон.

-7 ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгосонтой холбогдуулан 49.396.171 /дөчин есөн сая гурван зуун ерэн зургаан мянга нэг зуун далан нэг/ төгрөгийн тэтгэмж, 1.750.000 /нэг сая долоон зуун тавин мянган/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйл олгосон.

Үйлдвэрийн газрын захирлын 2022.02.28-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар зарим хэлтэс, төвийн ажилтнуудыг сул зогсолтод хамруулж нийт 65 ажилтанд олговор олгосон.

Үр бүтээлтэй ажилласан 18 ажилтныг Зам, тээвэр хөгжлийн яамны “Жуух бичиг”-ээр шагнасан.

Үйлдвэрийн газрын ажилтнуудын төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч автотээврийн салбарын байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан жилийн судалгааг шинэчлэн гаргаж, 2022.01.24-ний өдрийн А/35 дугаар тушаалаар алба, хэлтэс, төвийн 167, Улаанбаатар хот дахь зорчигч тээврийн болон техникийн хяналтын үзлэгийн 5 төвийн 136 ажилтан, аймгийн

Автотээврийн төв, салбарын 264 нийт 567 ажилтны ажилласан жилийн нэмэгдлийг тогтоон олгож байна.

Үйлдвэрийн газрын төв, алба, салбар, хэлтсийн удирдлага, ажилтнуудаас санал авсны үндсэн дээр “Үйлдвэрийн газрын ажилтны 2022 оны ээлжийн амралтын хуваарь”-ийг 2022.01.13-ны өдрийн А/23 дугаар тушаалаар батлан, хуваарийн дагуу ажилтнуудын ээлжийн амралтыг биеэр нь эдлүүлж байна. Тайлант хугацаанд алба, хэлтсийн болон Улаанбаатар хот дахь зорчигч тээврийн 2 төв, техникийн хяналтын үзлэгийн 3 төвийн нийт 100 ажилтан ээлжийн амралтаа эдэлсэн.

Нийт ажилтны ажлын сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор зөрчил дутагдал гаргаж үйлдвэрийн газрын “Хөдөлмөрийн дотоод журам”, Хөдөлмөрийн гэрээний холбогдох зүйл, заалтыг зөрчсөн ажилтны сахилгын зөрчлийг судалж, удирдлагад танилцуулж холбогдох шийдвэрийг гаргасан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 7 ажилтанд цалин бууруулах болон сануулах, 4 ажилтанд хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах сахилгын шийтгэл ногдуулсан.


Тайлант хугацаанд Үйлдвэрийн газрын ажилтан болон иргэдээс нийт 304 өргөдөл, хүсэлт, албан бичиг ирснээс 279 албан бичиг, өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэж, 25 өргөдөл, албан бичиг шийдвэрлэх шатандаа байна.

Дээрх хугацаанд хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой ирсэн албан бичиг, өргөдөл бүрийг судалж холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд тушаалын төслийг боловсруулан удирдлагуудад танилцуулан санал авч, үйлдвэрийн газрын захирлын тушаалаар шийдвэрлэсэн. Үүнд: /Б-300, А-155/

1.8. Хууль, эрх зүйн болон гэрээнд хяналт тавих үйл ажиллагааны хүрээнд:

Тус үйлдвэрийн газрын хэмжээнд бусад байгууллага, хувь хүнтэй байгуулж байгаа гэрээний хуулийн үндэслэлийг хянан, дугаар олгон ажиллаж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт **230** гэрээ байгуулагдсан.

Мөн тус үйлдвэрийн газрын хэлтэс, алба, тасаг болон нийслэл болон орон нутгийн төвүүдийн нийт **819** ажилтны хөдөлмөрийн гэрээг шинэчлэн ажилласан.



1. Үйлчилгээ үзүүлэх гэрээ- **133**
2. Ажил гүйцэтгэх гэрээ- **32**
3. Хөлсөөр ажиллах гэрээ -**9**
4. Хамтран ажиллах гэрээ – **24**
5. Түрээсийн гэрээ - **10**
6. Худалдах, худалдан авах гэрээ – **19**
7. Даатгалын гэрээ – **3** тус тус байгуулсан байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар тус үйлдвэрийн газарт нийт **18** хэрэг маргаан хянагдаж байгаа бөгөөд үүнээс иргэний хэргийн шүүхэд **13**, Захиргааны хэргийн шүүхэд **5** хэрэг маргаан хянагдаж байснаас он гарснаас хойш 20 удаагийн шүүх хурал болж, **4** хэрэг маргаан эцэслэн шийдвэрлэгдсэн байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар **14** хэрэг маргаан хянан хэлэлцэгдэж байгаа бөгөөд тухай бүр тайлбар гарган оролцоно. /Хуулийн хугацаагаар шийдвэрлэгдэнэ./

Хууль, эрх зүйн хүрээнд:

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтыг баталсан. Авлигын эсрэг хуулийн 10.3 заасны дагуу 2022.02.15-ны өдрийн дотор тус үйлдвэрийн газрын хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 137 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэг гаргуулан авсан. Мөн үйлдвэрийн газрын алба, хэлтэс, тасгийн үйл ажиллагаанд болон ажилтан албан хаагч нарт хууль эрх зүйн зөвлөгөөг тухай бүрт өгч байгаа бөгөөд хууль хяналтын байгууллага, аж ахуйн нэгж, иргэнтэй эрх зүйн асуудлаар харилцах, албан бичиг хүргүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа, зөвлөгөөг үзүүлэн ажиллаж байна.

1.9. Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй сурталчилж ажиллах ажлын хүрээнд:

Байгууллагын үйл ажиллагаа болон хийж хэрэгжүүлж буй арга хэмжээ, бодлого шийдвэрийг олон нийтэд ил тод, нээлттэй, шуурхай хүргэх арга хэмжээг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажилласан.



2022 онд байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, цаг үеийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор “Оюунлаг эргэлт” ХХК-тай АГГ-22/14 тоот, “Соёл пресс” ХХК-тай АГГ-22/15 тоот, “Улаанбаатар ньус” ХХК-тай АГГ-22/17 тоот, “Асу Медиа Видео сайт” ХХК АГГ22/16 “Пийк Медиа Групп” ХХК -тай АГГ22/19, “Ган үзэгтэн” ХХК -тай АГГ22/21 “Үндэсний шуудан” сонин-той АГГ22/18 тоот гэрээг тус тус байгуулан хамтран ажиллаж байна.

Мөн мэдээ мэдээллийг илүү цар хүрээтэй олон нийтэд хүргэх зорилгоор байгууллагын хэмжээнд сошиал баг үүсгэн мэдээллийг түргэн шуурхай хүртээмжтэйгээр хүргэж байна. Автотээврийн үндэсний төвийн албан ёсны пэйж хуудсанд 20 төрлийн мэдээ мэдээллийг давтамжтай байдлаар постер болон видео хэлбэрээр түгээн ажиллаж байна. Постер болон видеоны хүрээг брэнд бүүк ашиглан нэг загвараар бэлтгэж өөрсдийн гэсэн өнгө төрхтэй болсон.

1.10. Байгууллагын ажилтнуудын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтад хамруулах ажлын хүрээнд:

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын ажилтнуудын 2022 оны “Сургалтын төлөвлөгөө”-г батлан биелэлтийг ханган ажиллаж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 7 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 217 ажилтныг хамруулсан. Үүнд:

- 2022.03.04-нд ЗТХЯ-наас зохион байгуулсан “Жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл түүнээс урьдчилан сэргийлэх, эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй тодорхой асуудлаар хэлэлцэх үндэсний хэмжээний цахим хэлэлцүүлэг сургалтанд 34 ажилтан
- 2022.03.04-ний өдөр Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран үйлдвэрийн газрын нийт удирдах албан тушаалтнуудад “Авилгын гэмт хэрэг” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.
- 2022.03.15-17-ны өдрүүдийн хооронд Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтанд 21 албан хаагчдыг онлайнаар хамруулсан бөгөөд 6 албан хаагч сертификатаа авсан.

- 2022.04.06-нд ЗТХЯ, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн хамтарсан “Хуурамч бичиг баримтыг таних аргууд” сургалтанд 10 ажилтан
- 2022.05.22-нд Бүртгэл, лавлах үйлчилгээний 75 мэргэжилтэнг “Лавлах үйлчилгээний ажилтнуудын харилцааны соёл” сэдэвт мэргэшүүлэх сургалтыг ИМАСО институттэй хамтран зохион байгуулж хамруулсан.
- 2022.06.06-07-ны өдрүүдэд Монголын бүтээмжийн төвтэй хамтран бүтээмжийн тухай ойлголт, бүтээмж дээшлүүлэх үндсэн арга хэрэгсэл болох “Ажлын соёл 5S, Кайзен” хөтөлбөрийг үйлдвэрийн газарт хэрэгжүүлэх ойлголт ур чадвар олгох зорилготой сургалтанд алба, хэлтэс, Улаанбаатар хот дахь зорчигч тээврийн болон техникийн хяналтын үзлэгийн төв, аймгийн 21 Автотээврийн төв, 2 салбарын 77 албан хаагчдыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулан хамруулсан.
- 2022-05.23-2022.06.20-ны хооронд Судалгаа хөгжил, чанарын удирдлагын төвөөс явуулсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журам, стандарт, ХАБЭА-н хандлага зэрэг мэдлэгийг нэмэгдүүлэх” сэдэвт сургалтыг хамтран зохион байгуулж, нийт 370 ажилтанг хамруулсан.

Тайлант хугацаанд сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй доорх сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

- 2022.03.16-ны өдөр Нийслэлийн Прокурорын газар, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, Нийтийн тээврийн газрын эрх бүхий албан тушаалтнуудтай хамтарсан хяналтын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулсан.


1.11. Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааны хүрээнд:

Автотээврийн үндэсний төвд 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт ирсэн бичиг 3724 , явуулсан албан бичиг 829 байна.

“АТҮТ” ТӨҮГ-ын ирсэн, явсан бичиг болон захирлын тушаалын 2020, 2021, 2022 оны харьцуулалт

Д/д	Нэрс	2020 оны II улирал	2021 оны II улирал	2022 оны II улирал
1	Ирсэн бичиг	3186	2839	3724
2	Явсан бичиг	697	468	829
3	Захирлын тушаал	446	385	455

Графикаар үзүүлбэл:



ЗТХЯ-наас нийт **150** албан бичиг ирснээс хариутай албан бичиг **115** байна. Албан бичгийн шийдвэрлэлт **100%**-тай хэрэгжиж байна.

ТӨБЗГ-аас нийт **37** албан бичиг ирснээс хариутай албан бичиг **27** байна. Албан бичгийн шийдвэрлэлтийн хувь **100%**-тай байна.


Бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс нийт **2633** албан бичиг ирснээс **2541** хариутай албан бичиг байна. Нийт ирсэн албан бичгийн шийдвэрлэлт **99.6%**-тай хэрэгжиж байна.

2022 оны эхний хагас жилд үйлдвэрийн газрын захирлын нийт 455 тушаал гарсан. Үүнээс:
 А тушаал – 155
 Б тушаал – 300



Тус үйлдвэрийн газраас байгууллага, аж ахуйн нэгж иргэдэд явуулах албан бичгийг тухай бүр албан бичгийн стандартын дагуу хэвлэмэл хуудсанд хэвлэж, холбогдох газарт шуурхай хүргүүлэх, зохион байгуулах ажлын хүрээнд нийт **829** албан бичиг гадны байгууллага иргэдэд хүргүүлэн ажилласан.

2022 оны эхний хагас жилийн байдлаар тус үйлдвэрийн газраас ЗТХЯ-нд **124** албан бичиг, ТӨБЗГ-т **23** албан бичиг явуулсан.



Тус үйлдвэрийн газарт 2022.06.20-ны өдрийн байдлаар нийт **246** өргөдөл ирсэн. Үүнээс: Хүний нөөцийн чиглэлээр **199** үндсэн үйл ажиллагаатай холбоотой **47** өргөдөл ирсэн байна. Шийдвэрлэсэн **225**, хяналтад буюу шийдвэрлэх хугацаа болоогүй **21** өргөдөл байна. Өргөдлийн шийдвэрлэлт **91** хувьтай байна.

1.12. Байгууллагын архивын нөхөн бүрдүүлэлтийн ажлын хүрээнд:

Байгууллагын архивын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтийн дагуу 2021 онд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийг Алба, хэлтэс, тасгуудаас архивын стандартын дагуу үдэж хавтаслуулан нийт 86 боть хадгаламжийн нэгжийг байгууллагын архивт хүлээн авч архивласан.

Үйлдвэрийн газрын архивт байнга хадгалах хугацаа дууссан 2009-2013 оны 83 хадгаламжийн нэгжийг батлагдсан данс бүртгэлийн дагуу Үндэсний төв архивт шилжүүлэн өгч байнга хадгалах баримтыг төв архивт шилжүүлэн өгдөг хөмрөг үүсгэгч байгууллагаар бүртгүүлсэн.

Баримт бичгийн нэгдсэн сангийн баяжилтыг хийж ERP системийн тусгай хэрэглэгч цэсэнд Баримт бичгийн сан гэсэн дэд цэс нээн Монгол улсын хууль **29**, Засгийн газар хоорондын хэлэлцээр **14**, Засгийн газрын тогтоол **42**, Сайдын тушаал **110**, ТӨБЗГ-ын тогтоол **4**, Захирлын тушаал **89**, Албан даалгавар **11**, Заавар **13**, Стандарт **7**, Судалгааны ажлууд **13** нийт 332 баримт бичгийг цахим хэлбэрээр байршуулж, үйлдвэрийн газрын албан хаагчдад түгээн, баримт бичгийн нэгдсэн сангийн баяжилтыг тогтмол хийн ажиллаж байна.

1.13. Нийтлэг үйлчилгээний чиглэлээр:

Үйлдвэрийн газарт бүртгэлтэй нийт 58 тээврийн хэрэгслийн судалгааг шинэчлэн гаргасан бөгөөд төв албаны тээврийн хэрэгслүүдийг техникийн хяналтын үзлэгт хамруулсан. Мөн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, “Мөнх даатгал” ХХК-тай 2022.03.26-ны өдөр ДГ-22/02 дугаарт жолоочийн хариуцлагын гэрээ болон тээврийн хэрэгслийн гэрээг байгуулсан. Үйлдвэрийн газрын захирлын 2021.01.29-ний өдөр баталсан удирдамжийн дагуу төв алба болон Улаанбаатар хот дахь Зорчигч тээвэр болон Техникийн хяналтын үзлэгийн төвүүдэд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн ашиглалт, бүрэн бүтэн байдал, бусад шаардлагатай зүйлсүүдэд хяналт шалгалт хийсэн.

ТӨБЗГ-аас 2022.05.24-ний өдрийн А-1/1043 тоот албан бичгээр төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Тэргүүн дэд захирал болон дэд захирлуудын албан хэрэгцээнд ашиглаж байсан тээврийн хэрэгслүүдийг 2022.05.25-ны өдрийн дотор Засгийн газрын автобаазад хүлээлгэн өгөх мэдэгдэл ирүүлсэн бөгөөд дээрх мэдэгдлийн дагуу тус үйлдвэрийн газрын 2022.05.25-ны өдрийн 1/721 тоот албан бичгийн хавсралтад дурдсан тээврийн хэрэгслүүдийг Засгийн газрын автобаазад акт үйлдэн хүлээлгэн өгсөн.

Үйлдвэрийн газрын захирлын 2022.01.11-ний өдрийн А/21 тоот тушаалаар төв байрны урсгал засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан бөгөөд хамгийн сайн үнэлэгдсэн тендерт оролцогчоор “Хаан байц” ХХК-ийг сонгон шалгаруулж, Төв байрны ариун цэврийн өрөөний их засварыг ажил, төв байрны хурлын заалны их засварын ажлыг гэрээ байгуулж, гүйцэтгүүлж, акт үйлдэн хүлээн авсан. Мөн гадна талбайд үйлчлэгч, харуул, жолооч нарын дотоод нөөц боломжийг ашиглан талбайн засал, зүлэгжүүлэлт, цэцэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Covid-19 цар тахлын зэрэглэлийн түвшин буурсан ч ЗГ, УОК болон эрүүл мэндийн байгууллагуудаас гаргасан заавар зөвлөмжийн дагуу ариутгал халдваргүйжүүлэлт, агаар сэлгэлт, чийгтэй цэвэрлэгээг цаг тухай бүрт нь тогтмол хийж, ажиллаж байна.

1.14. Ахмадын хороо

Тайлан хугацаанд ахмадуудаас ирсэн 1 өргөдөл, хүсэлтийг судлан шийдвэрлүүлсэн. 2022 онд ахмадын хороонд бүртгэлтэй байгаа нийт ахмадуудын шинэчлэсэн бүртгэлийг гаргасан. Цагаан сарын баярыг тохиолдуулан автотээврийн салбарын ахмад настнуудад 2022.01.27-ны өдрийн А/38 тоот тушаалын дагуу дэмжлэг үзүүлэн ажилласан. Ахмадын хорооны ахмадуудын дархлааг дэмжих үүднээс ахмадын хороонд бүртгэлтэй нийслэлийн харьяалалтай 138 ахмадыг хамруулан Идэвхитэй амралт, спорт, аялалын үйл ажиллагааг 2022.06.03-04-ний өдрүүдэд зохион байгуулсан.

1.15. Хөрөнгө оруулалт, худалдан авалтын чиглэлээр

ТӨБЗГ-ын 2021.12.23-ны өдрийн 632 дугаар тогтоолоор тус үйлдвэрийн газрын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдсан. Уг тогтоолын дагуу үйлдвэрийн газрын захирал 2022 оны хөрөнгө оруулалт, худалдан авалтын нарийвчилсан төлөвлөгөөг баталсан.

Хөрөнгө оруулалтын нийт 14 нэр төрлийн 22 багц 2,746.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагаа төлөвлөгдсөн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжсэн 3 ажил, гүйцэтгэлийн шатандаа явж байгаа 7 ажил, сонгон шалгаруулалтын шатандаа явж байгаа 4 ажил, шууд худалдан авсан 3 ажил, Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөрт тусгагдсан зорилтот арга хэмжээг хөгжүүлж хэрэгжүүлэхтэй холбоотой эрх шилжүүлсэн 5 ажил байна.

Урсгал зардлын шинж чанартай 8 нэр төрлийн 12 багц 459,9 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар батлагдсан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжсэн 7 ажил, нийлүүлэлтийн шатандаа явж байгаа 1 ажил, хэмнэсэн 1 ажил, тендерийг зарлах хугацаа болоогүй 3 ажил байна.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Аймгийн автотээврийн төвүүд аймгуудын засаг даргын захирамжаар хуваарь гарган батлуулж 2022.03.21-ний өдрөөс 2022.06.20-ны өдрийн байдлаар алслагдсан сум суурин газрын 137,573 тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулсан байна.

“Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах” журмын 1.4-т заасныг үндэслэн Гадаад хэргийн яамны Дипломат ёслолын газартай хамтран гадаад орноос Монгол улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагуудын тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах хуваарь гаргаж, уг хуваарийн дагуу 153 тээврийн хэрэгсэлд хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулсан.

2.2 Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх ажлын онцлог, ач холбогдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах.

Техникийн хяналтын үзлэгийн үр дүн, ач холбогдлын талаар цаг үеийн шуурхай мэдээллээр хэвлэлийн мэдээ бэлтгэн доорх телевиз болон веб сайт, радиод ярилцлага өгч ажиллалаа. Medee.mn, MGL radio шууд нэвтрүүлэг, Zarig.mn, Live.tv, Zoogii.mn, Tug.mn, ivoice.mn Tv7 Mongolia телевиз

Тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд зориулж тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал тээврийн хэрэгслийн катализатор буюу нүүрсэн яндангийн таалархи мэдээллийг Medee.mn-р дамжуулан 2022.02.14-ний өдөр Сонгинохайрхан ТХҮТ-ийн инженер Ж.Доржготов, 2022.02.22-ны өдөр TV7 Mongolia телевизээр Баянгол ТХҮТ-ийн инженер М.Жамсранжав нар мэдээллийг өгсөн. 2022.02.14-ний өдрөөс эхлэн Нийслэлийн үзлэгийн төвүүдийн хаяг, байршил цагийн хуваарь, үзлэгийн төлбөр үнэ тарифын талаархи мэдээллийг Tug.mn, live.tv, zoogii.mn, ivoice.mn, Zarig.mn сайтуудаар дамжуулан мэдээллийг хүргэсэн.

Техникийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Эрдэнэмөнх 2022.05.10-нд ETV оройн мэдээ, 2022.05.24-нд “Зариг” хэлэлцүүлэг, 2022.05.25-нд Үндэсний шуудан сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд техникийн хяналтын үзлэгийн ач холбогдол болон тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж замын хөдөлгөөнд оролцох талаар мэдээллийг хүргэсэн.

2022.05.12-нд Баянгол техникийн хяналтын үзлэгийн төвийн инженер М.Жамсранжав-тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хорт бодис, Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн инженер Ж.Доржготов-мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарах зүйлсийн талаар автотээврийн үндэсний төвийн Facebook page хуудсаар дамжуулан тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд зөвлөмжийг хүргүүлсэн. 2022.06.13-ний өдөр TV9 телевиз өдрийн мэдээ тээврийн хэрэгслээс ялгарах хорт бодисын талаар Баянгол техникийн хяналтын үзлэгийн төвийн инженер О.Ганчулуун иргэдэд мэдээлэл хүргэсэн.

2.3 Холбогдох байгууллагуудыг тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн үр дүнгийн талаарх мэдээллээр хангах

Техникийн хяналтын үзлэгийн талаар цаг үеийн шуурхай мэдээллийг Техникийн хяналтын үзлэгийн сангаас хайх эрхийг холбогдох байгууллагад олгосоноор цаашид цаасан хэлбэрээр мэдээлэл хүргэх шаардлагагүй болсон. Төр, захиргааны болон шүүх, хяналтын байгууллага, Иргэд, аж ахуйн нэгжийн хүсэлт, албан бичгийг хүлээн авч боломжит мэдээллийг хүргүүлэн ажиллаж байгаа ба тайлант хугацаанд 320 байгууллага, аж ахуйн нэгжид мэдээлэл лавлагаа гарган өгч 425 тээврийн хэрэгслийн эзэмшигчийг хүлээн авч заавар зөвлөгөө өгч ажилласан.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Байгаль орчин, аялал жуучлалын сайд, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд /хуучнаар/-ын “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрс хүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилал тогтоох журам” 2011 оны А-63/67 дугаар хамтарсан тушаалын дагуу техникийн хяналтын үзлэгт хамрагдаж буй автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн ангилалын хэмжээг тогтоон <http://mvrs1.etransport.mn/mvrs/admin/auth.php> сайтаар дамжуулан Татварын байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэн ажиллаж байна.

Техникийн хяналтын үзлэгийн мэдээллийн сангийн хэвийн найдвартай ажиллагааг хангуулах, мэдээллийн шинэчлэлийг тухай бүрд нь саадгүй явуулах ажлыг хийж дараах байгууллагатай мэдээлэл солилцож байна. Үүнд:

- Замын хөдөлгөөний удирдлагын төв
- Тээврийн цагдаагийн газар
- Татварын ерөнхий газар
- Зам тээврийн хөгжлийн яам
- Үндэсний дата төв
- Мөн техникийн хяналтын үзлэг хийх чиглэлээр тусгай зөвшөөрөл авсан “Доктор авто сүлжээ”, “Монгол терминал” ХХК, “Нива трейд”, “Мөнх ерөөлт интернэйшнл” “Ти Эс Ти Тасган”, “Тайни касл”, “Замт моторс” ХХК-тай программ ашиглах гэрээ байгуулан ажиллаж байна.

Төр, захиргааны болон шүүх, хяналтын байгууллага, Иргэд, аж ахуйн нэгжийн хүсэлт, албан бичгийг хүлээн авч боломжит мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

2.4 Техникийн хяналтын үзлэгийн хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр нийтээр зохих эрх зүйн актанд өөрчлөлт оруулах

Хийгээр ажилладаг автотээврийн хэрэгслийн хаягдал утаан дахь хорт бодис, нэмэлт шаардлагыг шалгах талаар стандартын төслийг боловсруулсан. Уг стандартыг 1:1 буюу ISO стандарт болгох эсвэл MNS стандартаар батлуулах талаар судалгааг хийж байна.

2022.06.20-ны өдөр “Мэргэжлийн хяналтын ерөнхий газар”, “Тээврийн цагдаагийн алба”, “Зам, тээврийн хөгжлийн яам”, “Нийслэлийн тээврийн газар”, “ШУТИС-Механик тээврийн сургууль”-д хийгээр ажилладаг автотээврийн хэрэгслийн хаягдал утаан дахь хорт бодис, нэмэлт шаардлагыг шалгах талаар стандартын төсөлд санал авахаар хүргүүлсэн.

Техникийн хяналтын үзлэгийн технологийн картыг ачаа, суудал, механизм, мотоцикл, тусгай, чиргүүл, автобус гэсэн төрлүүдээр боловсруулж дууссан. Суудлын автомашины технологийн картыг боловсруулж, захирлаар батлуулсан. Технологийн картыг 120x150 хэмжээтэй нийт 26*7 байдлаар 182 ширхэгийг хэвлүүлж орон нутгийн болон Улаанбаатар хотын техникийн хяналтын үзлэгийн төвүүдэд хүргүүлж үзлэгийн байранд байршуулсан.

2.5. Чанарын удирдлагын тогтолцооны чиглэлээр:

Аймгийн Автотээврийн төвүүдийн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаанд MNS ISO 17020:2013 стандартын дагуу чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх ажлын хүрээнд:

Зам тээврийн хөгжлийн Сайдын 2021.12.31-ны өдрийн А/199 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Автотээврийн хэрэгсэлд техникийн үзлэг явуулах журам”-ын 2.3 шаардлагын дагуу чанарын удирдлагын тогтолцоо нэвтрээгүй байгаа нийт Үйлдвэрийн газрын Аймгийн автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаанд MNS ISO 17020:2013 стандартын дагуу чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Чанарын удирдлагын тогтолцоог дүнтэй хэрэгжүүлэхийн тулд 2022.02.09-ний өдөр “Удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх хөтөлбөр” болон хавсралтаар 2022.02.15-ний өдрөөс 2022.03.20-ны өдрийн хооронд “Нөөцөд дүн шинжилгээ хийх заавар”, “Сургалт зохион байгуулж, чадавхижуулах заавар”, “Үйл ажиллагааг баталгаажуулах заавар”-уудыг тус тус боловсруулж батлуулан ажиллав.



“Удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх хөтөлбөр”-ийн дагуу Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Дорнод, Замын-Үүд, Сүхбаатар, Ховд, Төв, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь аймгийн автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх чиглэлээр онлайн хурал, сургалт зохион байгуулсан. Мөн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаанд MNS ISO 17020:2013 стандартын дагуу боловсруулсан чанарын удирдлагын тогтолцооны баримт бичиг болох журам, заавар, бүртгэлүүдийг төв тус бүрд бий болгон бүрдүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

MNS ISO 17020:2013 стандарт нэвтэрсэн техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн чанарыг хангуулах ажлын хүрээнд:

- Чанарын удирдлагын тогтолцоо нэвтэрсэн болон нэвтрээгүй байгаа Үйлдвэрийн газрын нийт 24 салбар төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер, техникийн ажилтан болон дарга нарыг “Шударга байдлын мэдэгдэл”, нууцын баталгаа гаргуулах ажлыг 2022.01.15-ны өдрийн дотор зохион байгуулсан бөгөөд шинээр томилогдсон аймгийн автотээврийн төвийн дарга нараар тухай бүр “Шударга байдлын мэдэгдэл” гаргуулан ажиллаж байна.
- Чанарын удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр:
 - “Шударга байдал”, “Тээврийн хэрэгсэлтэй харьцах журам” сэдвүүдээр 2022.01.28-ны өдөр нийт техникийн хяналтын үзлэгийн инженер, техникийн ажилтнуудад сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.
 - Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төвийн үйл ажиллагаанд 2022.02.19-ний өдөр чанарын хяналт хийж, газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөмжийг өгч, үл тохирлыг залруулах ажлыг гүйцэтгүүлсэн.
 - Мөн 2022.03.03-ны өдөр үйлдвэрийн газрын Удирдах ажилтны зөвөлгөөнд “Техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааны итгэмжлэл”-ын ач холбогдол оролцооны талаар нийт аймгийн автотээврийн төвийн дарга нарт мэргэжил арга зүйн зөвөлгөө өгсөн.
- MNS ISO 17020:2013 стандартын дагуу чанарын удирдлагын тогтолцоо үр дүнтэй хэрэгжиж буй эсэхэд чанарын гарын авлагын 8.6.1 дэх шаардлагын дагуу ээлжит дотоод аудит хийсэн.
 - Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгийн автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаанд 2022.03.24-ний өдрөөс 2022.04.03-ны өдрийн хооронд;
 - Баянзүрх, Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвүүдэд 2022.06.08 болон 13-ний өдрийн хооронд;



Илэрсэн үл тохирлуудыг тухай бүр ТХХ-н шуурхай хуралдаанд танилцуулан Удирдлагын дүн шинжилгээний хурал хийж, дүн шинжилгээ хийж холбогдох заавар зөвлөмж өгч залруулах арга хэмжээг зохион байгуулан ажиллав. Дээрх арга хэмжээний дагуу нийт 43 үл тохирол шийдвэрлэгдэж, 3 үл тохирол шийдвэрлэгдэх шатандаа явж байна.

2.6. Итгэмжлүүлэх ажлын хүрээнд:

- Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвүүдэд Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2022 оны А/34 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2022.04.07-10-ний өдрийн хооронд MNS ISO 17020:2013 стандартын дагуу итгэмжлэлийн үнэлгээг газар дээр хийж гүйцэтгэсэн.

Үндэсний итгэмжлэлийн төвд тус үнэлгээгээр илэрсэн үл тохирлыг залруулж, тайланг хүргүүлсний дагуу 2022.05.02-ний өдөр Үндэсний итгэмжлэлийн төвийн техникийн хорооны хурлаар итгэмжлэх тухай хэлэлцэж, Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2022.05.05-ний өдрийн А/58 тоот тушаалаар 2026.05.05-ний өдөр хүртэл 4 жилийн хугацаатай итгэмжлүүлж, итгэмжлэлийн гэрээ байгуулан ажилласан.



Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн автотээврийн төвүүдэд Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2022 оны А/63 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2022.05.18-21-ний өдрийн хооронд MNS ISO 17020:2013 стандартын дагуу итгэмжлэлийн үнэлгээг газар дээр хийж гүйцэтгэсэн. Тус үнэлгээгээр илэрсэн 1,1 үл тохирлыг төлөвлөгөө гарган залруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

2.7 Хэмжлийн тоног төхөөрөмжийн чиглэлээр:

Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан техникийн хяналтын төвүүдэд ашиглагдаж байгаа тоормос шалгагч, тэнхлэг шалгагч, бензин утааны найрлага тодорхойлогч, дизель утааны тортогжилт шалгагч, тоормосны удаашрал хэмжигч, хайчин өргүүр, урд гэрлийн тусгал шалгагч зэрэг багаж тоног төхөөрөмжүүдийг давхардсан тоогоор 25 удаа дуудлагаар очиж эвдэрсэн тоног төхөөрөмжүүдийг газар дээр нь засвар хийж хэвийн ажиллагаанд оруулан засварласан байна.



Улаанбаатар хотын Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан техникийн хяналтын төвүүдийн нийт 106 ширхэг багаж, тоног төхөөрөмжүүдийн тохиргоо, зүгшрүүлэлтийг хийж дуусгалаа.

Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвд тоормос шалгагч, тэнхлэг хэмжигч, хайчин өргүүрийг 2022.02.28-аас 2022.03.18-ны хооронд шинээр сольж суурилуулсан. Мөн Мастер плаза төвд 2022.05.18-25-ны хооронд техникийн хяналтын үзлэгийн 1 шугамын тоног төхөөрөмжүүдийг суурилууллаа.

Дорнод, Ховд, Баянхонгор, Булган, Завхан, Хөвсгөл аймгуудын автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн тоормос шалгагч, бензин хөдөлгүүрээс ялгарах утааны найрлага тодорхойлогч, урд гэрлийн тусгал шалгагч багажуудыг онлайнаар холбогдож, шаардлагатай сэлбэг хэрэгслүүдийг хот хоорондын шугамын тээврийн хэрэгслээр явуулан засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан.

Орхон, Сэлэнгэ, Өмнөговь, Дорнод, Сүхбаатар, Архангай, Увс, Завхан аймгуудын автотээврийн төвийн техникийн хяналтын бензин утааны найрлага тодорхойлогч, дизель утааны тортогжилт шалгагч, тоормосны удаашрал хэмжигч, урд гэрлийн тусгал шалгагч, тоормос шалгагчийн удирдлага гэх мэт 11 ширхэг багаж, эд анги, тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч засварлан буцаан явуулаад байна.



Баянгол техникийн хяналтын үзлэгийн төвийн техникийн хяналтын тоног төхөөрөмжүүдийг 2022.05.07-15-ны хооронд салган авч Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн хажууд Лабораторийн байр, агуулах болон гадна хураасан.





2.8 Техникийн хяналтын үзлэгийн төвүүдэд орчин үеийн дэвшилтэд тоног төхөөрөмж нэвтрүүлэх

2021 оны хөрөнгө оруулалтаар худалдан авсан авто хийн алдагдал шалгагч багажийг Улаанбаатар болон орон нутгийн техникийн хяналтын үзлэгийн шугамуудад 1 улиралд хүлээлгэн өгсөн. Мастер плаза төвд 2022.05.18-25-ны хооронд дэвшилтэд технологийн тээврийн хэрэгслийн тоормос шалгагчийг шинээр суурилууллаа.



3.3. Техникийн хяналтын үзлэгийн инженер техникч нарт явуулсан сургалт

2022.03.25-ны өдөр техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн техникийн хяналтын үзлэгийн инженер, техникч нарт авто хийн алдагдал шалгагч тоног төхөөрөмж ашиглах, ажиллуулах сургалтыг зохион байгуулсан. Мөн 2022.05.18-ны өдөр “Тоног төхөөрөмжийн , ашиглалт, хамгаалалт, арчлалт”-ын талаар нийт инженер техникийн ажилчдад техникийн хяналтын хэлтсийн тоног төхөөрөмжийн ахлах инженер Э.Энхбаатар сургалт орсон.




ГУРАВ. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

“Автотээврийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу Монгол улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг мөрдөн автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг нийслэлийн 6 дүүргийн 13 салбар, 21 аймгийн 23 салбаруудаар дамжуулан нийт 89 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр улсын хэмжээнд зохион байгуулж байна.

3.1.ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Нийт тээврийн хэрэгсэл

Улсын хэмжээнд 2022.06.20-ны өдрийн байдлаар нийслэлд **681,622** /55,3 %/, орон нутагт **548,784** /44,7 %/ нийт **1,230,406** тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.




Шинээр бүртгэсэн тээврийн хэрэгсэл

Нийт **43840** тээврийн хэрэгслийг шинээр бүртгэсэн. 2021 оны мөн үеийнхээс **11564** тээврийн хэрэгсэл буюу **20%**-иар буурсан дүнтэй байна.




Шилжилт хөдөлгөөн

Нийт **260804** тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн өөрчлөлтийг бүртгэсэн. 2021 оны мөн үеийнхээс **92149** тээврийн хэрэгсэл буюу **54 %**-иар өссөн дүнтэй байна.



Тээврийн хэрэгслийн гэрчилгээ нөхөн олголт

Нийт **7027** тээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгосон байна. 2021 оны мөн үеийнхээс **1651** тээврийн хэрэгсэл буюу **30%-иар** өссөн дүнтэй байна.




Орон нутаг дахь бүртгэлийг аймгуудаар харуулвал

Импортын бүртгэл: Тайлант хугацаанд орон нутгийн 21 аймгийн 23 салбарт нийт **2173** автотээврийн хэрэгслийг шинээр бүртгэсэн.



Шилжилт хөдөлгөөн: Тайлант хугацаанд орон нутгийн 21 аймгийн 23 салбарт нийт **55,084** хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийг бүртгэсэн байна.



3.2 Бүртгэлийн үйл ажиллагаа

- Гадаад харилцааны яамны зөвшөөрлийн дагуу **40** тээврийн хэрэгсэлд ДК дугаар, ЗТХЯ-наас өгсөн чиглэл болон МАТНХ-ны албан бичгийг үндэслэн олон улсын тээвэрлэлт хийж байгаа **46** тээврийн хэрэгсэлд НАА серийн улсын дугаарыг тус тус олгосон.
- Замын-Үүд боомтоор нэвтэрсэн импортын тээврийн хэрэгсэлд түр дугаар олгож эхэлсэн ба 2022.06.20-ний өдрийн байдлаар **1099** тээврийн хэрэгсэлд түр дугаар олгож ажилласан.
- Холбогдох хууль, журам, удирдамжийн хүрээнд 2021.02.15-ны өдрөөс эхлэн 2022.05.13-ныг дуустал 16 удаагийн дуудлага худалдааг **auction.transdep.mn** цахимаар зохион байгуулж явуулсан.
- Улаанбаатар хотын УАО, УАР, УАС, УАТ, УАУ, УАХ, УЕА серийн нийт **2,709** ширхэг дугаарт давхардсан тоогоор **29,452** иргэн оролцож, **2,485** дугаар худалдан борлуулж **4,642,500,000** төгрөгийг төвлөрүүлсэн байна. Орон нутгийн нийт **65** улсын дугаар дуудлага худалдаанд орсон бөгөөд үүнээс **55** улсын дугаар борлуулагдан **67,350,000** төгрөгийг төвлөрүүлсэн байна. Нийт улсын дугаарын дуудлага худалдаанаас **4,709,850,000** төгрөгийг тусгай санд төвлөрүүлсэн.
- Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу **745** тээврийн хэрэгслийн шилжилтийн эрхийг хязгаарлаж, **187** тээврийн хэрэгслийн хязгаарлалтыг цуцалсан.
- Цаашид ашиглах боломжгүй болсон тээврийн хэрэгслээс нийслэлд **2609**, орон нутагт **9174** нийт **11783** тээврийн хэрэгслийг бүртгэлээс хассан.


3.3 Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах үйл ажиллагааны хүрээнд:

- **Нотариат:** Монголын нотариатчдын танхимын удирдлагуудтай 2022.01.27-ны өдөр уулзалт хийж программ хангамжийн сервисээ холбох, хамтран ажиллах гэрээ хийх болон зарим ойлголтын зөрүүг арилгах талаар санал солилцсон. Хамтран ажиллах гэрээг ЗТХЯ-тай байгуулсан. Сервис холбох явцад үүссэн зарим алдааг залруулан үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.
- **Цахим хүсэлт:** Тээврийн хэрэгслийн өмчлөл шилжүүлэхтэй холбоотой тоон гарын үсгээр баталгаажсан цахим хүсэлт илгээх технологийн боломж бүхий цогц системийг боловсруулан хөгжүүлэх ажлын хүрээнд эхний ээлжинд “Инвескор” ББСБ-тай туршилтын гэрээг байгуулан цахим хүсэлт авах ажил бэлэн болсон. Туршилтын ажил хийгдэж байна.
- **Цахим төлбөр:** Тээврийн хэрэгслийн Цирк дэхь салбарт үйлчилгээний хураамжийг банкны QPAY & SocialPAY ашиглан төлөх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.
- **Програмын хөгжүүлэлт:** Бүртгэлийн VRS программыг ЦЕГ-ын торгуулийн сайтыг хур системтэй холбон торгууль цэсийг нээн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Тээврийн хэрэгслийн торгууль төлөлтийн лог үүсгэхээр болсон. Мөн Татварын ерөнхий газрын МТХ, Бүртгэлийн хэлтсийн удирдлагуудтай уулзалт хийж, тээврийн хэрэгслийн мэдээлэл солилцох асуудлыг сайжруулах, АТҮТ-өөс мэдээлэл татах сервисийг өөрчлөх, тээврийн хэрэгслийн татвар төлөгдсөн эсэхийг шалгах төлөлтийн сервисийг АТҮТ-д өгөх зэрэг сайжруулалт хөгжүүлэлт хийх асуудлын талаар уулзалт хийж Мэдээллийн технологийн хэлтэстэй хамтран холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.
- **И-Монголия академитай** хамтран тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг цахимаар хийх боломж бүрдүүлсэн.

3.4 Архив, хяналтын тасаг

- Тус хэлтэст 2021 онд шинээр ажилд орсон 12 мэргэжилтний бүртгэсэн тээврийн хэрэгслийн бүртгэлийн баримт бичгийг 2022 оны 03 дугаар сард шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.
- Нийслэл орон нутгийн тээврийн хэрэгслийн бүртгэлийн нийт 68 мэргэжилтнээс 2022.02.08-ны өдөр тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хууль, журам, стандартын талаар 30 асуулт бүхий шалгалтыг цахимаар авч, дүнг танилцуулсан.

- Тус хэлтсээс ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн кримналистик шинжилгээний газартай хамтран ТХБХ-ийн нийслэл орон нутгийн нийт мэргэжилтнүүдэд хуурамч бичиг баримт, тамга тэмдэг хэрхэн таних талаар сургалтыг 2022.04.20-ны өдөр цахимаар зохион явуулсан.
- Нийслэлийн бүртгэлийн мэргэжилтнүүдийн мэдлэгийг бататгах зорилгоор тээврийн хэрэгслийн бүртгэлийн журам, стандарт болон хөгжөөнт асуулт бүхий “АХА” тэмцээнийг төв байрны хурлын зааланд 2022 оны 5 дугаар сард зохион байгуулсан.
- Архив лавлагааны тасагт **3** цонхоор лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлж **2022** оны эхний хагас жилд иргэн, аж ахуйн нэгжийн **2156** хүсэлтээр **53002** тээврийн хэрэгслийн лавлагаа гаргасан. Хууль хяналтын байгууллагаас ирсэн **4167** ширхэг тоот албан бичгийн дагуу **35481** тээврийн хэрэгслийн лавлагаа өгсөн. Энэ хугацаанд нийт **12682** хуудас баримтын хуулбар өгч ажиллалаа. ТҮЦ машинаас **5300** тээврийн хэрэгслийн лавлагааг иргэдэд олгосон



- Хууль хяналтын байгууллагууд буюу ЦЕГ, АТГ, ТЦА зэрэг байгууллагуудад VRS програм хангамжийг ашиглаж мэдээлэл харах эрх нээн шаардлагатай лавлагааг албан ёсны баримт олгох боломжийг бүрдүүлэн өгсөн.
- Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн явцад үүссэн баримт бичгээр хадгаламжийн нэгж болон цахим архив үүсгэх, тэдгээрийг хадгалах, хамгаалах, лавлагаа хуулбар олгох журам"-д нэмэлт өөрчлөлт орж тээврийн хэрэгслийн гэрчилгээг устгах боломжийг бүрдүүлснээр шилжилт хөдөлгөөний бүртгэлийн цаасан архивыг **25** орчим хувиар буурсан. Мөн бүртгэлийн маягт цахимд шилжсэнээр хадгаламжийн нэг нэгжид шилжилт хөдөлгөөний 150 орчим, импортын 50-53 материал орж нийт дүндээ **30%** орчим цаасан материал багассан.

3.5 Олон нийтэд хүргэсэн мэдээлэл

- Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагаа болон ашиглахгүй болсон тээврийн хэрэгслийг хасуулах, тээврийн хэрэгслийн өмчлөлийг тухай бүрт шилжүүлэх ач холбогдлын талаар 2022 оны 5 дугаар сард МҮОНТ, NTV, Eagle телевизэд, дуудлага худалдааны талаар TV8 телевизээр олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан.



- Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааны талаар ахлах мэргэжилтэн Ц.Батбаатар, Ш.Найдансүрэн нар поскаст ярилцлага хийж цахим орчинд байршуулсан.
- Мягмар гараг бүр MGL 88.3FM радиогийн шууд нэвтрүүлгээр холбогдож, иргэдийн асуусан асуултанд хариулж, мэдээлэл өгч байна.
- Ажлын өдрүүдэд 70070018, 70070030 дугаарын утсыг ажиллуулж, тээврийн хэрэгслийн бүртгэл, дуудлага худалдаатай холбоотой мэдээ, мэдээллийг өгч байна.
- Байгууллагын пэйж хуудас болон цахимаар тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааны зар болон сурталчилгааг тогтмол явуулж байна.
- Тээврийн хэрэгсэлтэй холбоотой тоон мэдээг тухай бүр шинэчлэн /төрөл ангилал загвар он гэх мэт/ гарган, үйлдвэрийн газрын фэйсбүүк хуудас болон 500 группт түгээж, олон нийтэд хүргэсэн.

ДӨРӨВ. ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

4.1 Улс хоорондын зорчигчийн тогтмол тээвэрлэлт

Улс хоорондын байнгын зорчигч тээвэрлэлтийг ОХУ, БНХАУ, БНКазахстан улсын 13 чиглэлд 17 аж ахуйн нэгж, байгууллагын 121 тээврийн хэрэгсэл, 247 мэргэшсэн жолоочтойгоор /давхардсан тоогоор/ тээвэрлэлт гүйцэтгэж байсан. ОХУ-тай хиллэдэг хилийн боомтуудын үйл ажиллагаа 2022.03.30-ний өдөр нээгдсэнтэй холбогдуулан “Улаанбаатар хот – ОХУ-ын Улан-Үдэ хот” чиглэл, “Сэ.Сүхбаатар – ОХУ-ын Хиагт хот” чиглэл болон “Сэ.Сүхбаатар - ОХУ-ын Улан-Үдэ хот” чиглэлүүдийн тээвэрлэлтийн үйлчилгээг 2022.04.01-ний өдрөөс эхлүүлсэн. “БНКаЗУ-ын Нур-султан хот – МУ-ын Бө.Өлгий сум” чиглэлийн тээвэрлэлтийн үйлчилгээг 2022.05.04-ний өдрөөс тус тус эхлүүлсэн.




График 1. Улс хоорондын зорчигч урсгал

4.2 Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ зохицуулалт, зохион байгуулалт

Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг **61** аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан **56** чиглэлд **708** тээврийн хэрэгсэл, **1475** мэргэшсэн жолоочтойгоор тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. Хот хоорондын чиглэлд 2022 оны эхний хагас жилийн байдлаар **599,4** мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс **87,6%**-аар өссөн байна.

Хот хоорондын зорчигч урсгалын судалгаа /мян.хүн/



График 2. Хот хоорондын зорчигч урсгал

Мэдээллийн санд хамрагдсан тээврийн хэрэгслүүдийг төрлөөр нь ангилахад 45 хүний суудалтай том оврын автобус **598**, 24-36 хүний суудалтай дунд оврын автобус **20**, суудлын автомашин **90** буюу нийт **708** тээврийн хэрэгсэл байна.





График 3. Тээврийн хэрэгсэл /төрлөөр/



Хот хоорондын нийтийн зорчигч тээвэрт явж буй тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл: том оврын тээврийн хэрэгсэл **84%**, дунд овор **13%**, суудлын тээврийн хэрэгсэл **3%**-г тус тус эзэлж байна.

График 4. Тээврийн хэрэгслийн эзлэх хувь


Хот хоорондын нийтийн тээврийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлууд:

Хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Тээвэр зохицуулагч нарын ур чадварыг нэмэгдүүлэх, ухаалаг тээврийн системийг хөгжүүлэх” тухай онол, практик хослуулсан бүсчилсэн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах” гэж төлөвлөсний дагуу 2022.03.30 – 2022.04.05-нийг

дуустал хугацаанд Зүүн бүсийн 3 аймгийн тээвэр зохицуулагч нарт сургалт хийсэн. Сургалтад 17 тээвэр зохицуулагч 6 гэрээт ажилтан хамрагдсан бөгөөд нийт 23 ажилтан хамрагдсан. 2022.04.11 –12-ний хугацаанд 2 зорчигч тээврийн төвийн 33 тээвэр зохицуулагч, лавлах үйлчилгээний 11 ажилтан хамрагдсан. 2022.04.13–23-ний өдрийг дуустал хугацаанд Баруун бүсийн 8 аймгийн тээвэр зохицуулагч нарт сургалт хийсэн. Сургалтад 35 тээвэр зохицуулагч, 1 гэрээт ажилтан, 4 тасалбар түгээгч хамрагдсан бөгөөд нийт 40 ажилтан хамрагдсан. 2022.04.26–2022.05.03-ний өдрийг дуустал хугацаанд Хойд бүсийн 5 аймгийн тээвэр зохицуулагч нарт сургалт хийсэн. Сургалтад 36 ажилтан хамрагдсан. 2022 оны хагас жилийн байдлаар 16 аймаг, 2 салбарын 143 ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулсан.



Тус сургалтаар ажилчдад сургалтаар шинээр батлагдсан дүрэм, журам, стандарт, шинэчилсэн гэрээ, нийтийн тээврийн өнөөгийн нөхцөл байдал болон зорчигч тээвэрлэлттэй холбоотой программ хангамжуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгсөн. Мөн сургалтын өмнө мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг авч, сургалтын дараа мэдлэг баталгаажуулах шалгалтуудыг авсан.



Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор зорчигч урсгал буурдаг тодорхой үеүдэд "Нэг чиглэл - Нэг үйлчилгээ"-г 2022 онд 2 чиглэлд туршихаар төлөвлөсөн. Эхний зорчигч урсгал буурдаг үе болох 3 дугаар сард "Нэг чиглэл - Нэг үйлчилгээ"-г "Улаанбаатар хот - Баян-Өлгий аймгийн Өлгий сум" чиглэлд туршихаар бэлтгэл ажлуудыг ханган суурь судалгаануудыг хийн аж ахуйн нэгж байгууллагуудад 2022.02.17-ний өдөр цахим хурлаар мэдээлэл өгөхөд аж ахуйн нэгж байгууллагууд тус үйлчилгээг туршихыг эсэргүүцсэн. Мөн "Лотот" ХХК 2022.02.28-ний өдрийн 35/0122 тоот албан бичиг болон "Зорчигч тээврийн Ховд" ХХК 2022.02.22-ний өдрийн 1/9 тоот албан бичгээр тус тус дэмжихгүй байгаа талаар мэдэгдсэн тул уг үйлчилгээг "Улаанбаатар хот – Өмнөговь аймгийн Даланзадгад сум" чиглэлд туршихаар шийдвэрлэсэн. Туршилтыг "Улаанбаатар хот - Дундговь аймгийн Сайнцагаан сум" болон "Улаанбаатар хот – Өмнөговь аймгийн Даланзадгад сум" чиглэлүүдийг нэгтгэн нэг чиглэл үүсгэн нэг үйлчилгээг 2022.03.01-ээс 2022.05.01-ний өдөр хүртэлх хугацаанд хийсэн.

Уг үйлчилгээг туршихаас өмнө "УБ – Ду.Сайнцагаан сум" чиглэлийн суудал ашиглалт 24,3%-тай, "УБ–Өм.Даланзадгад сум" чиглэлийн суудал ашиглалт 31,8%-тай байсан бол туршилтын хугацаанд үүсгэсэн нэг чиглэлийн суудал ашиглалт 47%-тай болсон бөгөөд "Хараацайн жигүүр" ХХК нь тус 2 чиглэлд 2 тээврийн хэрэгсэл дунджаар 28,5%-ийн суудал ашиглалттай чиглэлүүдэд тээврийн хэрэгсэл гаргах шаардлагагүй 1 чиглэлд 1 тээврийн хэрэгсэл

дунджаар 47%-ийн суудал ашиглалттайгаар тээвэрлэлтэд гаргаснаар суудал дүүргэлт 19%-аар өсөж, зардал буурсан.

№	Чиглэлийн нэр	Туршилтын өмнөх суудал ашиглалт /%/			Туршилтын дараах суудал ашиглалт /%/	
		2020.03.01 - 2020.05.01	2021.08.01 - 2021.10.01	Харьцуулалт	2022.03.01 - 2022.05.01	Харьцуулалт
1	УБ - Ду.Сайнцагаан	49%	24.3%	-24.7%	47%	22.7%
2	УБ - Өм.Даланзадгад	38%	31.8%	-6.2%		15.2%
Дундаж суудал ашиглалт		44%	28%	-15%	47%	19%


Хүснэгт 1. Туршилтын суудал ашиглалт

№	Чиглэлийн нэр	1 рейсийн орлого /с/а-100% байх үеийн/	1 рейсийн орлого /туршилтын өмнөх/	1 рейст гарах шатахууны зардал	Ашиг, алдагдал	1 рейсийн орлого /с/а-100% байх үеийн/	1 рейсийн орлого /туршилтын үеийн/	1 рейст гарах шатахууны зардал	Ашиг, алдагдал	Харьцуулалт
1	УБ - Ду.Сайнцагаан	1,556,000	426,000	990,150	(564,150)	1,556,000	741,000	1,167,250	(426,250)	(137,900)
2	УБ - Өм.Даланзадгад									
Дундаж		Дундаж 28%-ийн суудал ашиглалттай үед			Туршилтын 47%-ийн суудал ашиглалттай үед			24.4% буурсан		

Хүснэгт 2. Туршилтын үр ашгийн тооцоолол

Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор зорчигч урсгал буурдаг тодорхой үеүдэд "Өртөө тээвэр" зохион байгуулалтын үйлчилгээг 2022 онд 2 чиглэлд туршихаар төлөвлөсөн. Эхний зорчигч урсгал буурдаг үе болох 3 дугаар сард "Өртөө тээвэр" үйлчилгээг "Улаанбаатар хот - Увс аймгийн Улаангом сум" чиглэлд туршихаар бэлтгэл ажлуудыг ханган суурь судалгаануудыг хийн аж ахуйн нэгж байгууллагуудад 2022.02.17-ний өдөр цахим хурлаар мэдээлэл өгөхөд аж ахуйн нэгж байгууллагууд тус үйлчилгээг туршихыг эсэргүүцсэн тул туршил хойшлогдож 10 сард хийгдэхээр болсон.

ХХ59 дугаартай "Улаанбаатар хот-Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум" чиглэлийн үйлчилгээг 2022.03.02-ний өдрөөс, ХХ57 дугаартай "Улаанбаатар хот - Сэлэнгэ аймгийн Ерөө сум" чиглэлийн үйлчилгээг 2022.04.01-ний өдрөөс тус тус эхлүүлсэн.



**ТЭЭВЭРЛЭЛТ
ЭХЛЭЛЭЭ**


**УЛААНБААТАР - СЭЛЭНГЭ ЦАГААННУУР СУМ
СЭЛЭНГЭ ЦАГААННУУР СУМ - УЛААНБААТАР**

- **УЛААНБААТАР - СЭЛЭНГЭ ЦАГААННУУР СУМ** Лхагва гариг бүр 14:00 цагаас /Сонгинохайрхан зорчигч тээврийн төвөөс хөдөлнө./
- **СЭЛЭНГЭ ЦАГААННУУР СУМ - УЛААНБААТАР** Пүрэв гариг бүр 11:00 цагаас /Сэлэнгэ Цагааннуур сумаас хөдөлнө./

**Зорчих тасалбарын үнэ
тариф**

Том хүн-28000төгрөг
Хүүхэд-14000 төгрөг

Холбогдох утас: 1900-1234,
83031111, 93007722

 <p>Тээвэрлэлт ЭХТЭЛЭЭ</p>	<p align="center">УЛААНБААТАР - СЭЛЭНГЭ ЕРӨӨ СУМ СЭЛЭНГЭ ЕРӨӨ СУМ - УЛААНБААТАР</p> <ul style="list-style-type: none"> ● УЛААНБААТАР - СЭЛЭНГЭ ЕРӨӨ СУМ Даваа гариг бүр 08:00 цагаас / Сонгинохайрхан зорчигч тээврийн төвөөс хөдөлнө./ ● СЭЛЭНГЭ ЕРӨӨ СУМ - УЛААНБААТАР Даваа гариг бүр 16:00 цагаас /Сэлэнгэ Ерөө сумаас хөдөлнө./ <p>Зорчих тасалбарын үнэ тариф</p> <p>Том хүн-22000төгрөг Хүүхэд-11000 төгрөг</p> <p>Холбогдох утас: 1900-1234, 83031111, 93007722</p>
---	---

Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган аймгуудад 2022. 03.09-19-нийг хүртэл хугацаанд ажиллан Автотээврийн төвүүдийн зорчигч тээврийн зохион байгуулалттай танилцаж холбогдох хууль, дүрэм, журам, стандартын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн “Улаанбаатар хот – Дархан-Уул аймаг” чиглэлийн замын нөхцөл байдал болон орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан.

Баруун бүсийн 8 аймагт 2022.04.13-23-ний өдрийг дуустал хугацаанд ажиллан Автотээврийн төвүүдийн зорчигч тээврийн зохион байгуулалттай танилцаж холбогдох хууль, дүрэм, журам, стандартын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн орон нутагт байрлалтай 13 аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан.

ХХ02 буюу “Улаанбаатар-Баян-Өлгий-Улаанбаатар” чиглэлд хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч “Газрын-Од” ХХК “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ хооронд байгуулсан ХХНТ -098/2019 дугаартай гэрээний үүргийн биелэлтийг тээвэр зохион байгуулагчийн зүгээс “Хангалтгүй” гэж дүгнэснийг тээвэрлэгчийн талаас хүлээн зөвшөөрөхгүй, Зам, тээврийн хөгжлийн сайд болон, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандсаны дагуу үйлдвэрийн газрын захирлын 2022.06.08-ны өдрийн А/149 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь ажиллаж “Газрын –Од” ХХК-ийн Улаанбаатар хот, Баян-Өлгий аймаг дахь ажлын байруудаар явж бодит байдлыг тогтоон санал дүгнэлт гаргах чиглэлээр 2022.06.08-13-ны хооронд ажилласан. Илэрсэн зөрчлүүдийг үндэслэн тус аж ахуйн нэгж байгууллагын тээвэрлэлтийн үйл ажиллагааг 2022.06.16-ний өдрөөс зогсоосон.

Хот хоорондын нийтийн тээврийн үнэ, тарифт өөрчлөлт оруулах хүсэлтийг хот хоорондын нийтийн тээврийн 31 аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн саналыг судлан тооцоо, судалгааг хийн 2022.05.17-ний өдрийн 2/675 тоот албан бичгээр ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн. ЗТХЯ-наас ирүүлсэн 2022.05.23-ний өдрийн 07/2333 тоот албан бичгийг үндэслэн 2022.06.01-ний өдрөөс хот хоорондын нийтийн тээврийн үнэ, тарифт өөрчлөлтийг оруулан шинэчлэгдсэн тарифыг мөрдөн ажиллаж байна. Хот хоорондын нийтийн тээврийн үнэ тарифф зайнаас хамаарч 100 -26000 төгрөгөөр нэмэгдсэн.

Хот хоорондын нийтийн тээврийн тээврийн хэрэгслүүдийн насжилт болон осол, техникийн саатлын судалгааг хийн ЗТХЯ-ны АТБХЗГ-т 2022.05.17-ний өдрийн 2/680 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээний 1 дүгээр улирлын гэрээний үүргийн биелэлтийг 2022.04.01-15-ний өдрийг дуустал хугацаанд дүгнэсэн. Мөн дутагдалтай дүгнүүлсэн аж ахуйн нэгж байгууллагуудад албан мэдэгдэл, гэрээ дүгнүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагуудад хангалтгүй дүгнүүлсэн тухай албан бичгүүдийг тус тус хүргүүлсэн.

- ✓ 85-аас дээш оноо Хангалттай – 44 ААНБ-ын 71 гэрээ
- ✓ 70-85 оноо Дутагдалтай – 12 ААНБ-ын 12 гэрээ
- ✓ Тээвэрлэлт гүйцэтгээгүй – 13 ААНБ-ын 13 гэрээ
- ✓ Гэрээ дүгнүүлээгүй – 7 ААНБ-ын 8 гэрээ

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ийн 2022 оны цахим сэтгүүлийг 2022.03.09-нд гаргаж иргэд олон нийтэд цахим хуудаснуудаар дамжуулан хүргэсэн.



4.2 Жуулчин тээвэр

Жуулчин тээвэрлэлтийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээг 2022 оны хагас жилийн байдлаар 15 аж ахуйн нэгж байгууллагатай байгуулан 81 тээврийн хэрэгсэлд жуулчин таних тэмдэг /TOURIST наалт/-ийг олгон ажиллаж байна. Жуулчин тээврийн үйлчилгээ төрийн цахим үйлчилгээний <http://e-mongolia.mn> системд нэгдсэнтэй холбоотой төрийн цахим үйлчилгээний <http://e-mongolia.mn> системээр дамжуулан жуулчин таних тэмдэг / TOURIST/ авах хүсэлтүүдийг авч эхлээд байна.

4.3 Орон нутгийн нийтийн тээвэр

Орон нутгийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг 11 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан 8 аймгийн 45 чиглэлд тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. Орон нутгийн нийтийн тээврээр 2022 оны хагас жилийн байдлаар 449,4 мянган зорчигч тээвэрлэсэн байна. Орон нутгийн тээвэрлэлтийг хууль эрхзүйн хүрээнд зохион байгуулах, бүртгэлжүүлэх, хяналт тавих зорилгоор салбар төвүүдэд чиглэл өгч, онлайн уулзалт зохион байгуулж ажилласан.

4.4 Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох үйл ажиллагаа талаар

Монгол Улсын Авто тээврийн тухай хууль, Боловсролын тухай хууль болон Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010.05.07-ний өдрийн 161/229 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох журам”-ын дагуу зохион байгуулж байна. “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох мэргэжлийн шалгалтын комисс”-ыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021.11.04-ны өдрийн А/176 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. 2022 оны хагас жилийн байдлаар 16,979 жолоочоос давхардсан тоогоор 29,292 удаа шалгалт авч 13,249 жолооч шалгалт тэнцсэнээс 7,357 үнэмлэх хэвлэж олгосон.

Мэргэшсэн жолоочийн ангилалд:

	Нийт хамрагдсан	Нийт тэнцсэн	Хувь
➤ В ангилал -	589	288	49%
➤ С ангилал -	641	254	40%
➤ Д ангилал -	2727	880	32%
➤ СЕ ангилал -	14571	5691	39%

	НИЙТ	18528	6978	37 %
	<i>Мэргэжил дээшлүүлсэн байдал:</i>			
➤	Улс хоорондын ачаа тээвэр	9845	5556	56%
➤	Улс хоорондын зорчигч тээвэр	103	64	62%
➤	Жуулчин тээвэрлэлт	158	109	69%
➤	Аюултай ачаа тээвэрлэлт	658	407	62%
	НИЙТ	10764	6136	57%



2022 оны хагас жилд 6,663 жолооч мэргэшсэн жолооч болсон нь өмнөх оны мөн үеэс 0,5% -иар өссөн үзүүлэлттэй байна.

Аймаг орон нутгаас мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох ажлын хүрээнд:

Мэргэшсэн жолоочийн шалгалт авах үйл ажиллагааг иргэдэд хүндрэл чирэгдэлгүй зохион байгуулах үүднээс цахим сүлжээг ашиглан 2022 оны хагас жилийн байдлаар 17 аймагтай нийт 430 удаагийн холболт хийж давхардсан тоогоор 6630 удаагийн шалгалт авснаас 3526 жолооч тэнцэж, үнэмлэх авсан.

ТАВ. АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

5.1 Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах ажлын хүрээнд:

Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийг 11 боомтын чиглэлд 392 аж ахуйн нэгж байгууллагын 26083 тээврийн хэрэгсэл, 24112 мэргэшсэн жолоочтойгоор гүйцэтгэж байна.

Хүснэгт 1. Хилийн боомтуудад үйл ажиллагаа явуулж буй ААНБ, тээврийн хэрэгслийн тоо:

№	Тээвэрлэлтийн чиглэл	Аж ахуйн нэгжийн тоо	Тээврийн хэрэгслийн тоо
1	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Тавантолгой, Ухаа худгийн уурхайгаас Гашуун сухайт-Ганц мод боомтын чиглэлд	245	19797
2	Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгойн уурхайгаас Гашуун сухайт-Ганц мод боомтын чиглэлд	5	217
3	Өмнөговь аймгийн Гурван тэс сум Овоот толгой МАК, Хүрэншанд болон Терра Энержи ХХК-ийн Баруун ноён уул нүүрсний уурхайгаас Шивээ хүрэн - Сэхээ боомтын чиглэлд	53	3045

4	Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Айлбаянгийн уурхайгаас Ханги - Мандал боомтын чиглэлд	28	904
5	Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас -Эрээн боомтын чиглэлд	7	288
6	Дорнод аймгийн Матад сумын Хөөтийн нүүрсний уурхайгаас болон Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт - Зүүн хатавч боомтын чиглэлд	18	362
7	Дорнод Матад сумын Тамсагийн сав газраас Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт - Зүүн хатавч боомтын чиглэлд	2	20
8	Дорнод аймгийн Матад сумын Тамсагийн сав газраас Баянхошуу - Өвдөгт боомтын чиглэлд	4	108
9	Ховд аймгийн Дарви сумын Хөшөөтийн уурхайгаас Булган сумын Ярант Такашкен боомтын чиглэлд	29	1148
10	Говь-Алтай аймгийн Цээл сумын Таяннуурын уурхайгаас Бургастай - БНХАУ-ын Лаомяо боомтын чиглэлд	1	96
Дүн		392	25985

График 1.Хилийн боомтуудаар тээвэрлэсэн нүүрсний экспортын хэмжээ:





График 2.Хилийн боомтуудаар тээвэрлэсэн байгалын баялгийн экспортын хэмжээ:



ЗТХС-аас өгсөн чиглэлийн дагуу Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэгчтэй аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээ байгуулаад байна. Энэхүү гэрээг нь Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээр, хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай яамд хоорондын протокол, Захи

ргааны ерөнхий хуулийн 52.2.1, 52.2.3 дах заалтууд, Автотээврийн тухай хуулийн 6.1.10 дах заалт, 22 дугаар зүйл, Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2020 оны А/24 дүгээр тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 173 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улс болон БНХАУ-ын хооронд байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх автотээврийн хэрэгсэлд зорчих зөвшөөрлийн бичиг олгох журам, 2016 оны 76 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн байгуулаад байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-той хиллэдэг 6 боомтоор 13279, ШУӨЗО-той хиллэдэг 1 боомтоор 1861, нийт 15140 ширхэг улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийн “С” төрлийн зөвшөөрлийн бичиг хэвлэн олгосон байна.

Хүснэгт 2. Зөвшөөрлийн бичиг олголт 2022 оны 2-р улирлын байдлаар:

	Зөвшөөрлийн бичиг олголт				
	Боомт	С	D	E	F
ӨМӨЗО	Гашуунсухайт	12264	52	0	0
	Ханги	393	0	0	0
	Шивээхүрэн	497	0	0	0
	Замын-Үүд	42	0	0	0
	Баянхошуу	31	0	0	0
	Бичигт	52	0	0	0
	Нийт	13279	52	0	0
ШУӨЗО	Булган	1861	1043	0	95
	Бургастай	0	0	0	0
	Нийт	1861	1043	0	95
Нийт	15140	1095	0	95	

Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтын чиглэлд:

Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2022.02.14-ны өдрийн 12/37/A/30 тоот тушаалаар “Гашуунсухайт дахь тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулах журам” батлагдсан. Батлагдсан журмын хүрээнд Хилийн боомтын үндэсний зөвлөлийн Ажлын алба, Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа, Хилийн боомтын зөвлөл, Гашуунсухайт дахь Шуурхай штаб, АТҮТ, ЭМБ, МХБ, ЦБ, СОК, ХӨСҮТ зэрэг төрийн байгууллагууд хамтран улс хоорондын ачаа тээвэрлэлтийг удирдлага зохион байгуулалтаар ханган тээврийн үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэн битүүмжилсэн багийн системийг хяналт тавин ажиллаж байна. Үүнд:

Битүүмжлэгдсэн чингэлэг тээврийн 399 багийн 5567 жолооч, тээврийн хэрэгсэл, Терминалын чингэлэг тээврийн 78 багийн 365 жолооч, тээврийн хэрэгсэл нийт 142 аж ахуй нэгжийн 477, Битүүмжлэгдсэн тээврийн багийн 5932 жолооч, тээврийн хэрэгсэл Гашуунсухайт - Ганцмод боомтын чиглэлд улс хоорондын нүүрс тээвэрлэлт гүйцэтгэж байна. Задгай тээврийн нийт 113 багийн 1,260 жолооч, 1,260 т/х-ээр нүүрс тээвэрлэлт гүйцэтгэж байна.

Он гарснаас хойш өссөн дүнгээр 32,462 чингэлэг т/х-ээр 4,155,136 тн нүүрс, 5,620 т/х-ээр 224,800 тн зэсийн баяжмал экспортлосон болон 1,847 т/х-ээр бараа, материал импортоор орж ирсэн байна.

Тус журмын 2.3 Битүүмжлэгдсэн тээврийн багийн бүртгэл хөтлөх, дараах тохиолдолд бүртгэлд өөрчлөлт оруулах саналыг Боомтын захиргаанд хүргүүлнэ; 2.3.2.а. Тээвэрлэгч аж ахуй нэгж байгууллагаас тээврийн хэрэгслийн мэдээллийг өөрчлөх хүсэлт гаргасан тохиолдолд; 2.3.2.б. Жолоочийн гадаад паспорт өөрчлөгдсөн, шинээр авсан тохиолдолд шинээр олгогдсон гадаад паспортын дугаарын мэдээллийг шинэчлэх; 2.3.2.в. Битүүмжлэгдсэн тээврийн багийн жолоочийн шинжилгээний хариу эерэг гарсан, ар гэрийн гачигдал, өөрийн хүсэлтээр багаас гарсан тохиолдолд дараагийн жолоочийг нөхөн оруулах; заалтуудын дагуу 126 ААН-ын 209 албан бичгийн хүрээнд 650 жолоочийг нөхөх, хасах, 18 жолоочийн гадаад паспортын дугаар шинэчлэн өөрчлөх, 50 тээврийн хэрэгслийн мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай саналыг Хилийн боомтын үндэсний зөвлөл болон Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаанд 2022 оны 2/444, 2/461 тоот албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан.

Мөн тус журмын 2.2.2-т “Үндэсний зөвлөлийн Ажлын алба битүүмжлэгдсэн тээврийн баг үүсгэх асуудлыг энэхүү журмын 2.2.1-д заасан үзлэг тооллогын дүн, Хилийн боомтын зөвлөлөөс ирүүлсэн санал болон Автотээврийн үндэсний төвөөс ирүүлсэн тээврийн хэрэгсэл, жолоочийн мэдээллийг үндэслэн дүгнэж, битүүмжлэгдсэн тээврийн баг үүсгэх жагсаалтыг тухай бүр Хилийн боомтын үндэсний зөвлөлийн Нарийн бичгийн дарга баталгаажуулна” гэж заасны дагуу шинээр битүүмжилсэн тээврийн баг үүсгэхээр хүсэлт гаргасан 140 ААНБ-ын 339 багийн 4924 жолооч, тээврийн хэрэгслийн мэдээллийг Тээврийн нэгдсэн системийн мэдээлэлтэй тулган үзэж Боомтын бүрэн эрхэт захиргаанд huselshalgah@gmail.com цахим хаягаар өдөр тутам хүргүүлэн ажилласан.

Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх “С” төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг 2022 оны I дүгээр улиралд 143 ААНБ-ын 4941, II дугаар улиралд 142 ААНБ-ын 7323 тээврийн хэрэгсэлд тус тус олгосон байна.

Тус боомтын чиглэлд Тээврийн нэгдсэн системд 227 ААНБ-ын 24111 жолооч, 19968 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

Өмнөговь аймгийн Шивээхүрэн боомтын чиглэлд:

Тус боомт 7 сарын хугацаанд хөдөлгөөнгүй байсан ба 2022.05.25-ны өдрөөс эхлэн 55 тээврийн хэрэгсэл, 220 чингэлгийг дундын бүсэд солилцож тээвэрлэлтийг эхлүүлсэн. Ингэснээр тээвэрлэлтийг хэвийн явуулах нөхцөл бүрдсэн бөгөөд өдөрт дунджаар 64 тээврийн хэрэгсэл, 256 чингэлгээр нүүрс тээвэрлэлтийг хилийн дундын бүсэд чингэлэг солин тээвэрлэж байна.

Сүхбаатар аймгийн Бичигт боомтын чиглэлд:

Тус боомтын боомтын чиглэлд улс хооронд газрын тосны тээвэрлэлт гүйцэтгэж байсан жолоочоос Covid19 халдварын тохиолдол бүртгэгдсэнээс үүдэн 2021.09.13-ны өдрөөс өнөөдрийг хүртэл боомт хөдөлгөөнгүй зогссон бөгөөд 2021 онд өдөрт дунджаар нүүрс 20-30, газрын тос 20-

25 тээврийн хэрэгсэл хилээр нэвтэрдэг байсан. Бичигт боомтын үйл ажиллагаа, өнөөгийн нөхцөл байдал, тээвэр зохион байгуулалтын талаар 2022.03.27-ны өдөр Бичигт боомтод хуралдаж санал солилцсон бөгөөд тус хуралд ЗТХЯ-ны АТБХЗГ-ын дарга Ё.Жаргалсайхан, Автотээврийн үндэсний төвийн Дэд захирал Б.Мөнхгарьд, Ачаа тээврийн хэлтсийн мэргэжилтэн Г.Мөнхтулга, 0146 дугаар ангийн захирагч хурандаа О.Азхүү, Гаалийн газрын дарга Н.Амарбаатар, хилийн Тагнуулын газрын ажилтан Г.Мягмарсүрэн нар оролцсон.

Дорнод аймгийн Баянхошуу боомтын чиглэлд:

БНХАУ-ын Манжуур хотод Covid19 халдварын тохиолдол бүртгэгдсэнээс үүдэн 2021.11.29-ний өдрөөс өнөөдрийг хүртэл боомт хөдөлгөөнгүй зогсоод байсан ба БНХАУ-ын ӨМӨЗО-ны зам харилцаа, тээврийн танхимаас 2022.06.02-ны өдрийн 692 тоот албан бичиг тус үйлдвэрийн газарт ирүүлсэн. Хүсэлтийн дагуу боомтын чиглэлд газрын тос тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын бичиг баримтыг шалган БНХАУ-ын ӨМӨЗО-ны зам харилцаа, тээврийн танхимд 2022.06.16-ны өдрийн 1/818 тоотыг хүргүүлсэн.

Баянхошуу-Өвдөг боомтын улс хоорондын тээвэрлэлт 2022.06.20-ны өдөр эхэлсэн. “Мост ази” ХХК-ний 5, “Дорнын хөгжил транспорт” ХХК-ний 1, БНХАУ-ын Жилинхуаян компаний 4 нийт 10 тээврийн хэрэгслээр 2845,1 тонн газрын тос экспортолж, 10 хоосон чиргүүлтэй машин орж ирсэн. Зохион байгуулалтын хувьд Ачаатай машины кабиныг лацдаж, Өвдөг боомтруу оруулж, боомтын Гаалийн хяналтын хяналтын талбайд хятад ажилтнууд ачаатай чиргүүл салгаж, хоосон чиргүүл залгаж өгч ажиллаж байна.

Ховд аймгийн Булган боомтын чиглэлд:

Тус боомтын чиглэлд 2022.01.01-2022.06.15-ны өдрийн хооронд нийт 15,815 тээврийн хэрэгслээр 1,150,874.2 тн нүүрс тээвэрлэсэн байна. Өдөрт дунджаар 117 тээврийн хэрэгслээр нүүрс тээвэрлэж байна. 2022.06.15-ны өдрийн байдлаар 488 тээврийн хэрэгслээр 7,884.5 тн өргөн хэрэглээний бараа болон барилгын материал тээвэрлэсэн байна.

Дорноговь аймгийн Ханги боомтын чиглэлд:

Ханги боомтоор 2022.01.05-ны өдрөөс чингэлэг тээвэр эхэлсэн ба 2022.06.15-ны өдрийн байдлаар нийт 7,611 тээврийн хэрэгслээр 531,169.7 тн нүүрс, 279 тээврийн хэрэгслээр 20,688.7 тн хүдэр, 28 тээврийн хэрэгслээр 2,039.6 тн жонш тээвэрлэсэн байна. Өдөрт дунджаар 91 тээврийн хэрэгслээр нүүрс, 6 тээврийн хэрэгслээр төмрийн хүдрийн тээвэрлэлт хийж гүйцэтгэж байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд боомтын чиглэлд:

Монгол улсын ерөнхий сайдын 2021.12.27-ны өдрийн 196 дугаар захирамжийн хүрээнд тусгаарлалтын дэглэмд нэр бүхий 3 ААНБ-ийн 56 тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээ, 50 жолоочтой хариуцлагын гэрээ байгуулж, 2022.01.11-ний өдрөөс 2022.05.15-ны өдөр хүртэл тээвэрлэлтийг хийсэн.

Замын-Үүд сумын Онцгой комиссын зохион байгуулалтын дагуу 2022.05.16-ны өдрөөс иргэдийн 40 т/х, Хил хамгаалах ерөнхий газрын 30 хүртэлх тээврийн хэрэгслээр чингэлэг ачиж “0” цэгт хүргэж өгч ажиллаж байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод 2022.06.02-ны өдөр “КОВИД-19”-ын халдварын 7 тохиолдол илэрч, 2022.06.12-ны өдрийн байдлаар халдварын 409 тохиолдол илэрсэн байна. Үүнтэй холбогдуулан тус хотод хатуу хөл хорио тогтоон “0” зогсолт хийж, Эрээн хотруу ачаа оруулахыг түр хугацаагаар зогсоосон.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод “КОВИД-19”-ын халдварын тохиолдол илэрснээс хойш буюу 2022.06.02-14-ний өдрийг хүртэлх хугацаанд Улсын хилээр иргэдийн 379 тээврийн хэрэгсэл, Хил хамгаалах ерөнхий газрын 237 тээврийн хэрэгсэл, нийт 616 тээврийн хэрэгслээр 596 чингэлэг 12442 тонн ачаа тээвэрлэж, импортын 166 тээврийн хэрэгсэл орж ирсэн. Бүс нутгийн ложистикийн төвөөс Эрээн хотын чиглэлд 20*228, 40*455, нийт 683 чингэлэг буцсан.

Улсын хилээр нийт 2022.01.11-ний өдрөөс хойш 2022.06.14-ний өдрийн байдлаар 7781 тээврийн хэрэгслээр 9551 чингэлэг 188,001,1 тонн ачаа тээвэрлэж, импортын 2262 тээврийн

хэрэгсэл орж ирсэн. Бүс нутгийн ложистикийн төвөөс Эрээн хотын чиглэлд 20*1491, 40*3012, нийт 4503 чингэлэг буцсан. Замын-Үүдийн боомтод 2022.06.14-ний өдрийн 12:00 цагийн байдлаар 947 хоосон чингэлэг, "0" цэгт 20*18 чингэлэг, 40*51 чингэлэг тус тус байршуулсан байна. Бүс нутгийн ложистикийн төвөөс Улаанбаатар хотруу 8356 тээврийн хэрэгсэл, бусад аймаг орон нутагт 857 тээврийн хэрэгсэл, нийт 9207 тээврийн хэрэгсэл Замын-Үүд сумаас гарах хөдөлгөөнд оролцсон.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтын чиглэлд:

Тус боомтын орох чиглэлд 2022.06.20-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт 6,696 т/х-ээр 103,728.4 тн ачаа тээвэрлэсэн байна. Гарах чиглэлд нийт 6,966 т/х-ээр 1,243 тн ачаа тээвэрлэсэн байна.

Увс аймгийн Боршоо боомтын чиглэлд:

Тус боомтын орох чиглэлд 2022.06.20-ны өдрийн байдлаар нийт 811 т/х-ээр ачаа тээвэрлэсэн байна. Гарах чиглэлд нийт 788 т/х-ээр 80 тн ачаа ачиж гарсан байна.

Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтын чиглэлд:

Цагааннуур боомтын орох чиглэлд 2022.06.20-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт 3,021 т/х-ээр 31,837 тн ачаа, гарах чиглэлд 3,144 т/х-ээр 41.2 тн ачаа тээвэрлэсэн байна.

Говь-Алтай аймгийн Бургастай боомтын чиглэлд:

=Тус боомт 2022.04.28, 29-ний өдрүүдэд нийт 17 тээврийн хэрэгслээр 2,394.7 тн төмрийн хүдэр тээвэрлэсэн. 2022.06.20-ны өдрийн байдлаар хөдөлгөөнгүй байна.

5.2 Дотоодын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах ажлын хүрээнд:

Тус үйлдвэрийн газраас хот хоорондын ачаа тээврийн мэдээллийн сан үүсгэх, бүртгэлжүүлэх зорилгоор дотоодын ачаа тээвэр зуучлалын програм хангамжийг боловсруулан 2021 оны 4 дүгээр сард вэб хувилбарыг нэвтрүүлсэн. Уг программ нь ачаа илгээгч эсвэл хүлээн авагчийг тээвэрлэгчтэй холбож өгөх үндсэн үүрэгтэй хийгдсэн ба хот хоорондын тээвэрлэлт гүйцэтгэж байгаа иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын бүртгэл, хот хооронд тээвэрлэгдэж байгаа ачаа барааны мэдээллийн цахим сан үүсгэж, QR код бүхий цахим замын хуудсаар хяналт тавих боломжоор хангаж өгсөн онцлогтой.

Программыг <https://logistic.transdep.mn/> сайтаас гаргасан цахим замын хуудсан дахь QR кодыг интернет орчин шаардахгүйгээр шалгаад явах бүрэн боломжтой. Мөн дотоодын ачаа тээврийн <https://logistic.transdep.mn/> сайтны мобайл гар утасны аппликейшнийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан бэлэн болж, 2022.03.31-ний өдөр андройд гар утсанд зориулагдсан хувилбарыг Playstore-д байршуулсан.

Илгээмжийн ачааг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах ажлын хүрээнд:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/200 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах, тээвэрлэлийн ажил үйлчилгээг сайжруулах, зорчигч тээврийн автобуудлаар тав тухтай, соёлтой үйлчлүүлэх боломжийг хангах, сайжруулах зорилгоор ачаа тээшийг "Бүртгэлжүүлэх, түр хадгалах" үйлчилгээг олон нийтэд хүргэх зорилт тавин Баянхонгор, Увс, Завхан, Өвөрхангай, Дорноговь, Дархан-Уул аймгууд автобуудлаар дамжуулан илгээмжийн ачааг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

1. Баянхонгор аймгийн Автотээврийн төв 2022.01.07-ны өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд 2022.06.20-ны өдрийн байдлаар 8,269,198 төг төвлөрүүлэн ажиллаж байна.

2. Завхан аймгийн Автотээврийн төв 2022.01.23-ны өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд 2022.06.20-ны өдрийн байдлаар 2,997,300 төг төвлөрүүлэн ажиллаж байна.

3. Дархан-Уул аймгийн Автотээврийн төв 2022.03.12-ны өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд 2022.06.20-ны өдрийн байдлаар 3,658,662 төг төвлөрүүлэн ажиллаж байна.

4. Өвөрхангай аймгийн Автотээврийн төв 2022.02.14-ний өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд 2022.06.20-ны өдрийн байдлаар 1,617,600 төг төвлөрүүлэн ажиллаж байна.

5. Архангай аймгийн Автотээврийн төв 2022.01.01-ний өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд 2022.06.20-ны өдрийн байдлаар 1,169,388 төг төвлөрүүлэн ажиллаж байна.

6.Увс аймгийн Автотээврийн төв 2022.02.18-ны өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд 2022.06.20-ны өдрийн байдлаар 931,788 төг төвлөрүүлэн ажиллаж байна.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь уурхайгаас Говьсүмбэр аймгийн Чойр өртөө- чиглэлийн нүүрс тээвэрлэлт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/164 дугаар тушаалаар “Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Тавантолгой уурхайгаас Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум” хүртэлх авто замаар нүүрс тээвэрлэлтийг 2022.03.31-ний өдөр хүртэл гүйцэтгэх болсонтой холбогдуулан “Автотээврийн Үндэсний төв” ТӨҮГ нь тус чиглэлийн тээвэр зохион байгуулалтын бэлтгэл ажил, хяналт шалгалтын хэрхэн зохион байгуулах боломжийг судлах, нөхцөл байдалтай танилцахаар, Зам тээврийн хөгжлийн төвтэй хамтран 2021.10.27-оос 2021.11.01-ний өдрүүдэд албан томилолтоор ажилласан.

Тус чиглэлийн нүүрс тээвэрлэлтийг хэвийн, тасралтгүй явуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, оролцож буй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, авто замын засвар арчлалт, түүнд хяналт тавьж буй төрийн байгууллага, орон нутгийн удирдлага, иргэний болон төрийн бус байгууллагуудын эрх үүргийг тодорхой болгох зорилгоор 5 удаагийн хурал, зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Мөн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг оролцогч талуудтай хамтран боловсруулж, тээвэрлэлтийн явцад олон салаа зам гаргахгүй байх, байгаль орчны бохирдол, хог хаягдал зэрэгт иргэний болон нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Уурхай эзэмшигч нартай зам засварын хураамж төлсөн, хот хоорондын ачаа тээврийн замын хуудас олгогдсон тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагын тээврийн хэрэгсэлд квот олгож, ачилтад олгохоор шийдвэрлэсэн.

Хүснэгт 3. Уурхайнуудаас тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэл, нүүрсний хэмжээ:

№	Уурхай	2022.01 сар		2022.02 сар		2022.03 сар		Тайлбар
		т/х-ийн тоо	тонн	т/х-ийн тоо	тонн	т/х-ийн тоо	тонн	
1	“Эрдэнэс таван толгой” ХК	851	76516	277	26578	163	15332	
2	“Таван толгой” ХК	108	9358	436	35918	247	21013	
3	“Энержи ресурс” ХХК тус чиглэлд ачилт хийгдэхгүй байгаа гэсэн мэдээлэл өгсөн.							
Нийт		959	85874	713	62496	410	36345	

Худалдан авагч, тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагааны чиглэлээр:

Өм.Цогтцэций-Гс.Чойр чиглэлийн авто замаар нүүрс тээвэрлэлт хийдэг тээврийн компаниудын удирдлагууд нь 2021.11.02-ны өдөр бүх гишүүдийн хуралдаанаар төлөөлөн удирдах зөвлөл, зөвлөлийн тэргүүнээ сонгосон нэгэн зорилгын хүрээнд нэгдэн ажиллах Чойр зөвлөлийг байгуулсан бөгөөд 2022.02.28-ны өдөр хуралдаж, Чойр зөвлөлийг улсын бүртгэлд албан ёсоор бүртгүүлэх, мөн “Элит консалтинг” ХХК-тай байгуулсан гэрээг дуусгавар болгож 2022.03.01-ний өдрөөс эхлэн бие даан үйл ажиллагааг явуулахаар шийдвэрлэсэн.

“Өм.Цогтцэций- Гс.Чойрын эрдэс тээвэрчдийн холбоо” ГҮТББ нь зөвхөн гишүүддээ үйлчлэх бөгөөд Өм.Цогтцэций-Гс.Чойр чиглэлийн авто замаар нүүрс тээвэрлэхээр нүүрс худалдан авагч гадаадын хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан.

Говьсүмбэр аймагт нүүрс ачиж, буулгах зориулалтын гаалийн хяналтын талбайн гэрээтэй, үндсэн тээврийн компаниудад хамаарах бөгөөд үндсэн тээврийн компани нь туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажлаа гүйцэтгүүлэх боломжтой байхаар зохион байгуулалт хийсэн.

“Цогтцэций-Чойрын эрдэс тээвэрчдийн холбоо” ГҮТББ нь сар бүр гишүүдийн хурлыг хийдэг ба тухайн сард хийгдсэн ажлын тайланг хэлэлцэн, буулгалтын талбайн мэдээ, тээвэр хийх компанийн мэдээллийг нэгтгэж 03 дугаар сард тээвэрлэх нийт нүүрсний хэмжээг тооцож гишүүнчлэлийн татварыг нэг тонн тутамд /5000төг/ байхаар тогтоосон бөгөөд уг татвараас нэг тонн тутамын /1200төг/ “Ханцэц гурвансайхан” ТББ, “Их говийн тээвэрчдийн холбоо” ТББ-д олгохоор шийдвэрлэсэн.

“Цогтцэций-Чойрын эрдэс тээвэрчдийн холбоо” ГҮТББ-ийн гишүүн нь гишүүнчлэлийн татвар төлдөг бөгөөд уг татварын орлогыг “Өм.Цогтцэций-Гс.Чойр” чиглэлийн авто замын засвар, арчлалтын зардал, нөлөөллийн бүсийн иргэдийн цалин, урамшуулал, орон нутагт нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж ажлууд болон зөвлөх, туслах хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төлбөрүүд, холбогдох бусад зардлыг санхүүжүүлдэг болно.

Өм.Цогтцэций-Гс.Чойр улсын чанартай авто замаар нүүрс тээвэрлэлтийг хэвийн, тасралтгүй явуулах нь хамтын ажиллагааны гол зорилго тул энэхүү зорилгоо биелүүлэх үүднээс Өмнөговь аймгийн “Ханцэц гурвансайхан” ТББ, “Их говийн тээвэрчдийн холбоо” ТББ-тай хамтран ажиллах гэрээг байгуулахаар тохиролцож уг төрийн бус байгууллагууд нь Цогтцэций сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх 92 км дагуух авто замын засвар, арчлалт, нөлөөллийн бүсийн иргэдийн цалин болон орон нутагт нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх ажил, арга хэмжээг бие даан хэрэгжүүлэхээр хариуцан ажиллаж байна.



Мөн Зам тээврийн хөгжлийн төвөөс өгсөн чиглэлийн хүрээнд “Велдедлайн монголиа” ХХК-тай зам засвар, арчлалтыг гэрээг байгуулан 2022.03.11-ний өдрөөс Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумаас эхлэн маршрутын зам дагуу зогсоон татах ажлын эхлүүлээд байна.

“Цогтцэций-Чойрын эрдэс тээвэрчдийн холбоо” ГҮТББ-ийн гишүүнчлэлтэй 32 тээврийн компаниас энэ сард “Эрдэнэс таван толгой” ХК уурхайгаас 6 гэрээ, “Таван толгой” ХК уурхайгаас 5 гэрээ, “Энержи ресурс” ХХК-аас 1 гэрээний ачилт хийгдэж, үндсэн 12 тээврийн компани түүний туслан гүйцэтгэгч 28 компанийн 562 тээврийн хэрэгсэл бүртгэлтэйгээс 200 орчим тээврийн хэрэгсэл тогтмол тээвэрлэлт гүйцэтгэж байна.

5.3 Авто үйлчилгээний чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын хүрээнд:

Авто үйлчилгээний мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй 559 авто үйлчилгээ эрхлэгч байгаа бөгөөд тэдгээр нь 36412 тээврийн хэрэгсэлд давхардсан тоогоор 49023 засвар хийж, засварын түүх үүсгэсэн байна. Мөн импортын тээврийн хэрэгсэл цэснээс давхардсан тоогоор

1663997 гаалиар орж ирсэн тээврийн хэрэгслийн мэдээллийг харсан байна. Цахимаар Хэнтий аймгаас 7, Дорноговь аймгаас 10, Говь-Алтай аймгаас 3, Өмнөговь аймгаас 5, Говьсүмбэр аймгаас 1, Орхон аймгаас 9, Архангай аймгаас 5, Баян-Өлгий аймгаас 3 буюу нийт 43 ангилал тогтоолгох хүсэлт ирүүлсэн байна. Үүнээс Хэнтий аймгийн 1, Баян-Өлгий аймгийн 3, Говь-Алтай аймгийн 2 хүсэлт журмын шаардлагыг хангаж ангиллаа тогтоолгож, гэрээ байгуулсан. 37 хүсэлт шаардлага хангаагүй тул холбогдох имэйл хаяг болон утсаар холбогдож буцаагдсан талаар мэдэгдсэн.

Авто үйлчилгээний мэдээллийн санд хийгдсэн хөгжүүлэлтүүд:

- Програм дахь мэдээлэл тайланг харах
Авто засварын мэдээллийг он оноор харах, татаж авах /exl/
Ангилал тогтоолгосон байдал он оноор харах, татаж авах /exl/
- Засвар үйлчилгээний мэдээллийг байршил, байгууллага, огноогоор нь ялган харах, татаж авах /exl/
- Ангилал тогтоолгох цахим хүсэлтийн шаардлага хангасныг Автотээврийн төв, салбарын дарга баталгаажуулдаг байхаар өөрчлөлт оруулсан.

Орон нутгийн Автотээврийн төвүүд болон тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээ эрхлэгчдэд 2022.01.26-ны өдрийн цахимаар “Авто үйлчилгээний байгууллагад тавигдах шаардлага болон авто үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сангийн ашиглалт”-ын талаар 2022.06.06-ны өдөр орон нутгийн Автотээврийн, салбаруудад эрх зүйн талаар мэдлэг олгох сургалт тус тус зохион байгуулсан.

ЗТХС-ын 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/112 дугаар тушаалаар Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам шинэчлэгдсэн батлагдсан. Уг журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан АТҮТ-ийн захирлын 2022.06.02-ны өдрийн “Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох тухай” А/145 дугаар тушаал батлагдсан.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэлжүүлэх зорилгоор судалгааны маягт боловсруулан 2022.06.03-ны байдлаар судалгааг авсан. Аймгийн төвүүдэд үйл ажиллагаа явуулж буй 99 ААНБ, 366 иргэн буюу нийт 465 авто үйлчилгээ эрхлэгч байна. Үүнээс агрегат засварын үйлчилгээ үзүүлдэг 109, кузов засвар 36, явах эд ангийн засвар 145, цахилгаан засвар 38, дугуй засвар 81, авто угаалга 157, тос тосолгоо сэлбэгийн худалдаа 194, авто зогсоол 14, оёдол доторлогоо 6 тус тус үйл ажиллагаа явуулж байна.

График 3.Орон нутагт авто үйлчилгээ эрхлэгчдийн тоо:




График 4. Орон нутагт Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйлчилгээний нэр төрөл:

Үйлчилгээний нэр төрлөөр нь ангилбал худалдаа 25%, авто угаалга 20%, явах эд анги засвар - 18%, агрегат -14%, дугуй засвар -10%, цахилгаан засвар -5%, зогсоол -2%, оёдол -1%- ийг тус тус эзэлж байна.

ЗУРГАА. ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА, ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

6.1 Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын чиглэлээр:

Тайлант хугацаанд улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн **29417** удаагийн тээвэрлэлтийг хянаж, шуурхай зохицуулалтаар хангаж ажилласан нь өмнөх оны мөн үеийнхээс 9,3 дахин өссөн үзүүлэлттэй байна.




График 1.1 Сүүлийн 6 жилийн төлөвлөгдсөн тээврийн хэрэгслийн тоог сараар харьцуулан графикаар үзүүлбэл:

Тайлбар: Covid-19 вирусын цар тахалтай холбоотойгоор 2021.01.01-2021.02.28-ны хооронд болон 2021.03.15-2021.05.22-ны хооронд хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ яваагүй.

Тайлант хугацаанд зам, тээврийн осолд холбогдсон 7 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 5 нь шүргэлцэх төрлийн осол байсан бол 2 нь 1 иргэн нас барж, 3 иргэн бэртэж гэмтсэн, осол байсан.

Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн аж ахуйн нэгж, байгууллагуудын тээврийн хэрэгслийн саатлын тоо 2020 оны хагас жилд 201, 2021 оны мөн үед 36 байсан бол 2022 оны хагас жилд 190 удаагийн саатал бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс нэгж тээвэрлэлтэд ногдох саатал 0,5 хувиар буурсан, тээвэрлэлт хэвийн гүйцэтгэж байсан 2020 оны хагас жилтэй харьцаалахад 0,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 1.4 Сүүлийн 6 жилийн хагас жилийн байдлаар улс, хот хоорондын нийтийн зорчигч тээвэрлэлтэд гарсан техникийн саатлын тоог харьцуулан графикаар үзүүлбэл:



Онцгой нөхцөл байдал буюу зам, тээврийн осол болон цаг агаар, замын нөхцөл байдлаас шалтгаалан тээвэрлэлт хүндэрсэн үед зохион байгуулсан арга хэмжээнүүд:

Үйлдвэрийн газрын захирлын “Онцгой нөхцөл байдал үүссэн нөхцөлд ажиллах шуурхай ажиллагааны бүлэг байгуулах тухай” 2020.02.03-ны өдрийн А/36 дугаар тушаалаар үйлдвэрийн газрын шуурхай бүлэг ажиллаж байна.

Тус шуурхай бүлэг нь цаг агаар, замын нөхцөл байдлаас шалтгаалан зорчигчдын амь нас, эрүүл мэндэд эрсдэл учирч болзошгүй нөхцөл үүссэн болон гэнэтийн осол, саатлын үед тээвэрлэлтийг шуурхай зохион байгуулан ажилладаг бөгөөд 2022.03.22-24-ний өдрийн хүчтэй цасан болон шороон шуурга шуурсан цаг агаарын хүндрэлээс шалтгаалан зорчигчдын амь нас, эрүүл мэндэд эрсдэл учирч болзошгүй нөхцөл үүссэн тул 1 тээврийн хэрэгслийн 25 зорчигчийг сум суурин газар байршуулж, 4 тээврийн хэрэгсэл /77 зорчигчтой/-ийн тээвэрлэлтийг хойшлуулах арга хэмжээг авч ажилласан.

Нийт нутгаар 2022.04.10-ны өдөр орсон цасны улмаас Архангай аймгийн Эрдэнэбулган, Түвшрүүлэх сум, Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт халтиргаа хулгаа үүссэн тул 6 тээврийн хэрэгслийн 203 зорчигчийг суурин газар байршуулсан.

Хойд болон баруун зүгийн нутгаар 2022.04.13-15-ны өдрүүдэд их хэмжээний цас орсны улмаас Дарханы Цайдамаас Хустайн даваа, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын хойд хэсгээр, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумаас Нарийнтээл сумын хоорондох улсын чанартай А0302 авто замын нөхцөл байдал хүндэрч тээвэрлэлт гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул зорчигчдын ая тухтай зорчих, аюул осолгүй тээвэрлэлт гүйцэтгэх зорилгоор болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажилласан. Тухайн өдрүүдэд:

-Нийт 19 чиглэлийн 640 зорчигчтой 45 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг цаг агаар, замын нөхцөл байдал сайжиртал түр хязгаарласан.

-Орон нутгаас тээвэрлэлтэд гарсан 125 зорчигчтой 3 чиглэлийн 5 тээврийн хэрэгслийг Баянхонгор аймагт, 44 зорчигчтой 3 тээврийн хэрэгслийг Говь-Алтай аймагт, Улаанбаатар хотоос тээвэрлэлтэд гарсан 194 зорчигчтой 5 чиглэлийн 8 тээврийн хэрэгслийг Өвөрхангай аймагт тус тус түр байршуулах, зорчигчдыг хоол унд, орон байраар хангах ажлыг зохион байгуулсан бөгөөд нийт 333 зорчигчтой 16 тээврийн хэрэгслийг /давхардсан тоогоор 27 тээврийн хэрэгслийн 653 зорчигч/ түр байршуулан холбогдох 25,887,000 /хорин таван сая найман зуун наян долоон мянга/ төгрөгийн зардлыг даатгалын байгууллагаас гаргуулан ажилласан.

Тус үйлдвэрийн газар нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн даатгалын зуучлагч болох “Нэйшнл эженси” ХХК-тай 2019.05.15-ны “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, зорчин явагчийн гэнэтийн ослын даатгалын нөхөн төлбөрийн асуудлыг тухай бүр шийдвэрлүүлж байна.

Тээвэрлэлтийн явцад эрүүл мэндээрээ хохирсон 2 иргэнд 769,224 төгрөг, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал 8,000,000 төгрөг, цаг агаар замын нөхцөл байдлаас шалтгаалсан саатлын үед 26,287,000 төгрөг, нийт 35,056,224 төгрөгийн нөхөн төлбөрийг даатгалын байгууллагаас шийдвэрлүүлсэн байна.

➤ **Ачаа тээвэр:**

Тайлант хугацаанд “Гашуун сухайт боомт”-оор ачаатай 37951 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн. Шивээ хүрэн боомт 2022 оны 05 дугаар сараас эхлэн ажилласан бөгөөд ачаатай 1553 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн. Замын-Үүд боомт covid-19 вирусын цар тахалтай холбоотойгоор ажиллаагүй болно. Бусад боомтоор нийт 31553 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн байна.

Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234

“Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234” тусгай дугаарын үйлчилгээ нь “Лавлах үйлчилгээний тасаг” болж 14 мэргэжилтэн, 1 хариуцсан ахлах мэргэжилтэнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийлүүлэн 2022.04.11-ний өдрөөс 24 цагаар ажиллаж эхэлсэн бөгөөд оргил ачааллын цагуудад нийт 6 шугам ажиллаж байна. “Автотээврийн

нэгдсэн лавлах 1900-1234” үйлчилгээний үүсгэгч сүлжээг 2022.06.03-ны өдрөөс “Онлайн Нетворк ХХК”-ны сүлжээнд шилжин ажиллаж байна.

Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаараар 2022.06.20-ны өдрийн байдлаар нийт 302,017 дуудлага хүлээн авч 150,905,927 төгрөгийн орлогыг “АТҮТ” ТӨҮГ-ын дансанд төвлөрүүлсэн. Өмнө жилийн мөн үетэй харьцуулахад /125,063 дуудлага/ 41,4 хувиар өссөн дүнтэй байна.



2022 оны нийт дуудлагын 71,4% хувийг /215,817/ гарц, зам, машин хааж тавьсан иргэдтэй холбогдох хүсэлт ирсэн бол авто үйлчилгээний талаар 59 удаагийн дуудлага ирсэн нь хамгийн бага хувийг эзэлж байна. 2022.06.20-ны өдрийн байдлаар дундажаар 41,7 хувийн дуудлага алдагдалтай ажиллаж байна.

2022.06.20-ны өдрийн байдлаар 150,905,927 сая төгрөгийн орлогыг “АТҮТ” ТӨҮГ-ын дансанд төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 35 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үйлчилгээний чанарыг сайжруулах ажлын хүрээнд хийгдсэн ажил

- Үйлдвэрийн газрын захирлын 2022.02.28-ны өдөр баталсан лавлах үйлчилгээний мэргэжилтнүүдийг чадавхижуулах, мэдээ мэдээллээр хангах сургалтыг 2022.03.05-ний өдөр зохион байгуулж, нийт 12 алба хаагч хамрагдаж 7 хэлтэс, тасгийн хариуцсан мэргэжилтнүүд ирж хөтөлбөрийн дагуу лавлах үйлчилгээний мэргэжилтнүүдэд тус тусын хэлтсийн үндсэн үйл ажиллагааг танилцуулж, лавлах үйлчилгээнд тулгамдаж буй асуудлыг ярилцаж, шийдвэрлэж чадаагүй асуудлаа тухайн хэлтэст бичгээр хүргүүлэхээр хэлэлцсэн. Сургалт зохион байгуулснаар лавлах үйлчилгээний мэргэжилтнүүд нэгдсэн мэдээлэлтэй болж иргэд үйлчлүүлэгчдэд үйлдвэрийн газрын үйл ажиллагааг үнэн зөв, түргэн шуурхай хүргэх, мэдээллийн зөрүүтэй байдал үүсэхгүй байх нөхцөл бүрдсэн.
- 2022.01.24, 2022.05.05-ний өдөр ETV телевизээр, 2022.04.28-ний өдөр NTV телевизээр, зам гарц, тээврийн хэрэгсэл хааж тавьсан тээврийн хэрэгслийн эзэмшигчтэй холболт хийх үйлчилгээний талаар мэдээллийг, 2022.02.17-ний өдөр MNB телевизээр орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээнд иргэдээс ирдэг санал хүсэлт, гомдлын талаар мэдээлэл, 2022.05.10-ний өдөр ETV телевизээр 70071234 дугаарыг АТҮТ-ийн албан хаагч болон үйл ажиллагааны талаар санал хүсэлт, гомдол хүлээн авахаар ажиллуулж эхэлсэн зэрэг мэдээллүүдийг өгч, олон нийтэд танилцуулсан.
- 2022.04.12-ний өдөр MGL радиод Автотээврийн нэгдсэн лавлах 24 цагаар ажиллаж эхэлсэн мэдээллийг иргэдэд хүргэсэн. Мөн “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын пэйж хуудсаар Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаар 24 цагаар ажиллаж эхэлсэн мэдээлэл хүргэсэн. Түүнчлэн “Үндэсний шуудан” сонины 2022.05.12-ны өдрийн №089 (4038) дугаарт Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 дугаар 24 цагаар ажиллаж

Автотээврийн салбартай холбоотой мэдээ мэдээллийг хүргэж байгаа талаар мэдээлэл тавигдсан.

- 2022.06.20-ны өдрийн байдлаар санал хүсэлт, гомдол бүртгэлийн хуудсаар нийт 39 гомдлыг бүртгэж холбогдох хэлтэс, албанд шилжүүлсэн бөгөөд үүнээс 29 гомдол буюу 74,3 хувийг шийдвэрлэж, 10 гомдлын шийдвэрлэлтийн хариу ирээгүй байна. 1900-1234 тусгай дугаарт ирсэн нийт 1497 санал хүсэлт, гомдлыг утсаар шууд шийдвэрлэнэ ажилласан.
- Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаарын үйлчилгээгээр иргэд олон нийтэд үйлдвэрийн газрын Авто үйлчилгээний эрхтэй орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Дугуй засвар, Авто угаалгын мэдээллийг 24 цагаар хүргэж эхлээд байна.
- 2022.04.30, 2022.05.01-ний өдрүүдэд AUTO MOTO VIP FESTIVAL-д оролцож 1900-1234 тусгай дугаарын үйлчилгээг иргэд олон нийтэд танилцуулсан.

6.2 Автотээврийн хяналт, шалгалтын чиглэлээр хийгдсэн ажлууд

2022 оны хагас жилийн байдлаар хот хоорондын нийтийн зорчигч, ачаа тээвэр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллага болон жолооч нарын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьж, иргэд зорчигчдын тав тухыг хангуулж ажилласан. Тус ажлын хүрээнд Зам тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын бодлого чиглэлийг мөрдлөг болгон, тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хууль тогтоомж, тушаал шийдвэр, дүрэм журам, стандартын заалтыг тайлбарлан таниулах, ухуулан сурталчлах, тэдний ажлыг туслан дэмжиж, илэрсэн дутагдал зөрчлийг арилгуулах, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар Зорчигч тээврийн 7361, ачаа тээврийн 3587, тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч тээврийн 165 тээврийн хэрэгслүүдийг шалгаж нийт 776 зөрчилд 85.750.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулж 9054 иргэнд зөлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Тус үйлдвэрийн газрын дэд захирлын 2022.01.03-ны өдөр баталсан хяналт шалгалтын удирдамжийн дагуу дотоодын ачаа тээвэр болон зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудын тээврийн хэрэгсэлд зам дундын хяналт шалгалт хийж ажилласан. Тус шалгалтыг Төв аймгийн Баянчандмань сум, Багануур дүүргийн Хэрлэнгийн гүүрэнд зохион байгуулсан. Мөн тус үйлдвэрийн газрын дэд захирлын 2022.01.27-ны өдрийн баталсан “Цагаан сар-тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч тээвэр” хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2022.01.28-2022.02.10-ны өдрүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан. Шалгалтаар нийт зорчигч тээврийн 132, ачаа тээврийн 46 тээврийн хэрэгслийг шалгасан.

2022 оны хагас жилд өдөр тутмын үйл ажиллагаагаар зорчигч тээврийн 7361 тээврийн хэрэгслийг шалгаж, тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлсэн 165 иргэнд 16.500.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

2022.06.21-ний өдөр Улаанбаатар хотоос баруун аймгийн чиглэлд тээвэрлэлт гүйцэтгэж байгаа ААНБ-ын тээврийн хэрэгсэлд шугам замын хяналт шалгалт хийж ажилласан. Шалгалтанд нийт 16 тээврийн хэрэгсэл хамрагдаж, зөрчилтэй 2 тээврийн хэрэгслийн бичиг баримтыг хураан авч, холбогдох арга хэмжээг авсан.

Тус үйлдвэрийн газрын захирлын 2022.03.16-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу дэд захирал Ц.Эрдэнэчулуунаар ахлуулсан ажлын хэсэг 2022.03.17-19-ний өдрүүдэд Говьсүмбэр, Дорноговь аймаг мөн Замын-Үүд салбарын ажилтнуудад ачаа тээвэр, хөдөлгөөний удирдлагын чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

“Өм.Цогтцэций-Гс.Чойр чиглэлийн эрдэс тээвэрчдийн холбоо” ГҮТББ-ийн гишүүнчлэлтэй 32 ААНБ-аас 3 сард “Эрдэнэс таван толгой” ХК уурхайгаас 6 гэрээ, “Таван толгой” ХК уурхайгаас 5 гэрээ, “Энержи ресурс” ХХК-аас 1 гэрээний ачилт хийгдэж, үндсэн 12 тээврийн компани түүний туслан гүйцэтгэгч 28 компанийн 562 тээврийн хэрэгсэл бүртгэлтэйгээс 200 орчим тээврийн хэрэгсэл тогтмол тээвэрлэлт гүйцэтгэж байгаа бөгөөд ААНБ болон жолооч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

2022.04.01-2022.05.01-ний өдрийн хооронд ЗТХЯ-аас зохион байгуулж буй олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгах, арчлалт хамгаалалтад анхаарах, замын эвдрэл гэмтлийг багасгах, “Автотээврийн техникийн байдалд

тавих ерөнхий шаардлага” MNS4598:2020 стандартын шаардлага хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар ЗТХЯ, ЗТХТ, ТЦА-тай хамтарсан “Саадгүй тээвэр-Сайн замаар” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Хяналт шалгалтаар удаа дараа зөрчил гаргасан ААНБ-уудад АТХУБ-ийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Тус арга хэмжээний хүрээнд нийт 3105 тээврийн хэрэгслийг шалгаж 1098 тээврийн хэрэгслийн зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан. Даац хэтрүүлсэн 76 зөрчилд 11.135.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Цаашид жин тонн хэтрүүлэн ачихгүй байх талаар тээвэрлэлт гүйцэтгэж байгаа иргэн, ААНБ-ууд болон жолооч нарт зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 48 ААНБ-ын 128 тээврийн хэрэгсэлд аюултай ачааны стандартын шаардлага хангасан тухай АТХУБ-ийн дүгнэлт гаргасан.

Мөн хүнсний түргэн муудах эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэсэн 86 тээврийн хэрэгслийг шалгаж ажилласан ба хяналт шалгалтыг 11 дүгээр сараас эхлэн сарын хугацаатай зохион байгуулахаар төлөвлөсөн.

Тээврийн нэгдсэн системд улс хоорондын байнгын ачаа тээврийн 25838 тээврийн хэрэгсэлд АТХУБ-ийн шалгах хуудсаар шалгуулах хүсэлт ирүүлснээс Автотээврийн улсын байцаагч нар 23657 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтыг хийж Тээврийн нэгдсэн системд бүртгэсэн, шаардлага хангаагүй болон шийдэгдээгүй 3892 хүсэлт байна.

➤ *Сургалт*

2022.02.17-ны өдөр хот хоорондын нийтийн зорчигч тээврийн ААНБ-уудын жолооч нарт “Төв орон нутагт гарсан зам, тээврийн осол, хэрэг, зөрчлийн статистик тоон судалгаанд үндэслэн урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах нь” сэдэвт сургалт, зөвлөлдөх уулзалтыг ТЦА-аас АТҮТ-тэй хамтран зохион байгуулсан. Тус сургалт, уулзалтаар зам, тээврийн ослын үеийн анхан шатны мэдлэг, ослын тоон үзүүлэлт жишээ баримтууд, замын түгжрэл, техникийн зохион байгуулалт, орон нутгийн замын эвдрэл гэмтлийн тухай мэдээлэл хүргэсэн. Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг төлөөлж zorig.mn, Eagle tv, Mass tv, News channel, Seven tv ирж оролцсон.

Тус үйлдвэрийн газрын дэд захирлын 2022.03.14-ний өдрийн баталсан “Сургалт зохион байгуулах” тухай удирдамжийн дагуу Нийслэлийн прокурорын газар, Нийслэлийн нийтийн тээврийн газартай хамтран Улаанбаатар хотын АТХУБ нарт Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн талаарх сургалтыг 2022.03.16-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтад Улаанбаатар хотын 15 алба хаагч хамрагдсан.

Microsoft excel програмыг үр дүнтэй ашиглах, томъёогоор тооцооллыг автоматаар гүйцэтгэн төрөл бүрийн функц ашиглан боловсруулалт хийж сургах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төв болон 10 салбарын алба хаагчдад зориулсан цахим сургалтыг 2022.04.29-05.06-ны өдрүүдэд АТХ-тэй хамтран зохион байгуулсан.

Үйлдвэрийн газраас 2022.05.22-ны өдөр “ИМАСО” сургалтын төвийн “Харилцааны ёс зүйн сургалт”-ыг зохион байгуулсан. Тус сургалтанд лавлах үйлчилгээний 13 мэргэжилтэн, 8 АТХУБ мөн ТХБХ-ийн 37 мэргэжилтэн хамрагдсан.

2022.06.17-ны өдөр МХЕГ, ЗТХЯ, Нийслэлийн тээврийн газартай хамтарсан сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд нийт 21 аймгийн Автотээврийн хяналтын мэргэжилтэн болон МХЕГ, ЗТХЯ, Нийслэлийн тээврийн газрын 72 эрх бүхий албан тушаалтан хамрагдсан.

Улаанбаатар хот болон орон нутгийн хэмжээнд давхардсан тоогоор 9 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 256 жолооч хамрагдсан.

ДОЛОО. СУДАЛГАА, ХӨГЖИЛ, ЧАНАРЫН ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР


7.1 Хийгдсэн томоохон судалгааны ажлууд

Цахилгаан автомашиныг нарны цахилгаан үүсгэврээр цэнэглэх судалгаа, туршилт

1992.05.09-нд Нью-Йорк хотноо батлагдсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь Конвенцийг (UNFCCC) – баталсан бөгөөд энэхүү конвенцийн өргөтгөсөн гэрээ буюу Китогийн протоколыг 1997.12.11-ний өдөр Японы Киото хотод байгуулж 2005.02.16-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж байна. УИХ -ын 1999.07.08-ны өдөр баталсан “Протокол соёрхон

батлах тухай” хуулийн хүрээнд манай улс Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь Конвенцийн 1997.12.11-ний өдрийн Киотогийн Протоколд нэгдэн орсон. BMW, TOYOTA, GM зэрэг автомашин үйлдвэрлэгч томоохон корпорациуд 2030 он гэхэд автомашин үйлдвэрлэлийн нийт хүчин чадлын 35-85 % -ийг зөвхөн цахилгаан автомашин(EV) үйлдвэрлэх замаар 2050 он гэхэд 100% цахилгаан автомашин(EV) үйлдвэрлэгч болох “Vision zero” дэвшүүлэн ажиллаж байна. Гэсэн хэдий ч цахилгаан автомашины (EV) хөгжил нь батарейн бүрэн цэнэгтэй үед туулах зай дотоод шаталт хөдөлгүүртэй автомашинтай харьцуулахад бага, цэнэглэх хугацаа урт, батарейн ашиглалтын дараах дахин боловсруулалт, цэнэглэх дэд бүтцийн хязгаарлагдмал байдал, эзэмшигчийн шинэ технологийн мэдлэг ойлголт гэсэн нөлөөлөх хүчин зүйлстэй тулгарч байна.

График 2. “Nissan leaf” загварын автомашин /EV/ -ны тоо үйлдвэрлэсэн оноор



Манай улсын автотээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн санд 2021 оны 06 сарын байдлаар 371 ширхэг цахилгаан тээврийн хэрэгсэл бүртгэлтэй бөгөөд үүний 61.7% буюу 229 нь NISSAN LEAF маркийн автомашин байна. Хэрэглэгчийн судалгааны түүврийн тоог тогтоохдоо нийт 371 эх олонлогоос санамсаргүй түүвэрлэлтийн аргаар төлөөлөх чадвартай 120 түүврийг сонгон авч судалгаанд хамрууллаа. Батарейг дүүрэн цэнэглэсэн үед NISSAN “LEAF” маркийн цахилгаан автомашин өвлийн улиралд 50-70 км, хавар, намар, зуны улиралд 70-100 км Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцдог байна. Манай улсын хувьд дэлхийн чиг хандлагаруу нэгдэн орох эко орчин бүрдүүлэх цахилгаан автомашины дэд бүтцийг шийдэх, импортоор орж ирж буй цахилгаан автомашины тоог нэмэгдүүлэх, хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх, хууль эрх зүйн таатай нөхцлийг бий болгох холбогдох стандарт, журмыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.




Судалгааны хүрээнд нийт 36 улс орны бодлого хөтөлбөрүүдийг судалж цахилгаан автомашины тоог нэмэгдүүлэх, дэд бүтэц, хэрэглэгч, нийлүүлэгчийг дэмжих ажлын хүрээнд эдгээр улс орнуудад төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр болон хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж дээрх судалгааны эмхтгэлийг боловсруулсан болно.

ЗТХЯ-ны гадна талбайд 40квт нарны эх үүсвэр суурилуулах” төслийн гүйцэтгэгч “Дүйнхэр тэргүүн” ХХК-тай хамтран судалгааны ажлыг эхлүүлсэн. Судалгааны ажлын даалгаврын хүрээнд ONGRID системийн цахилгаан үйлдвэрлэлийн өдөр тутмын үзүүлэлт, туршилтын хугацаан дах Улаанбаатар хотын цаг уур, агаарын бохирдолын хэмжээ, явган замын халаалтын системийн ажиллагаа зэрэг мэдээллийг цуглуулсан. ЗТХЯ-ны эрчим хүчний хэрэглээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Засгийн газрын байрнуудын нийтлэг үйлчилгээний газар” УТҮГ-аас авч судалгааны мэдээлэл боловсруулалт хийж байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр төлөвлөгөөт хугацаандаа эхний шатны тайланг ЗТХЯ-нд хүргүүлж, редакцийн санал авахаар ажиллаж байна.

Автотээврийн хэрэгсэлд сууриллуулах утаа шүүгчийг дотоодод үйлдвэрлэх боломжийг судлах

Монгол улсын хэмжээнд нийт бүртгэгдэж байгаа тээврийн хэрэгслийн тоо сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өсөлттэй байна. Мөн 2021 онд 1 243 445 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.5% буюу 106711 тээврийн хэрэгслээр нэмэгдсэн байна. Үүнээс үүдэн тээврийн хэрэгслээс ялгарах хорт утаа болон түүний хорт нөлөөлөл ихэсч байна гэсэн судалгаа байна. Энэхүү судалгаа хийгдсэнээр ач холбогдол нь дотооддоо утаа шүүгч үйлдвэрлэх боломжийн суурь судалгаа болох юм. Судалгааны ажлын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж гүйцэтгэж байна. Үүнд:

- Автотээврийн хэрэгслээс ялгарах хорт утааны нөлөөллийг судлах
- Утаа шүүгчийн төрөл ангилал, онцлогийг тодорхойлох
- Олон улсын туршлагыг олон талаас судлах
- Утаа шүүгчийг дотоодод үйлдвэрлэх боломжийг тодорхойлох



Судалгааны ажлын эхний шатны тайланг 2022 оны 1/239 тоот албан бичгээр ЗТХТ-д хүргүүлсэн ба ЗТХТ-аас ирсэн санал зөвлөмжийг тусгаж эцсийн шатны тайланг 2022 оны 1/814 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн математик загварчлал боловсруулах.

Судалгааны ажлын хүрээнд хот хоорондын зорчигч урсгалын хэмжээ, үр ашиг, техник ашиглалт зэрэг үзүүлэлтүүдийг тооцох математик загварыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах зорилготой ба дараах зорилтыг дэвшүүлж байна. Гэрээгүй тээврийн хэрэгслээр зорчиж буй зорчигчдоос урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу судалгаа авах, “Драгон” төв дээр нэг өдрийн ажиглалт хийх зэргээр анхдагч эх үүсвэрээс мэдээлэл цуглуулан ажиллалаа. Мөн үйлдвэрийн газрын Тээвэр зохицуулалтын хэлтэс, Хөдөлгөөн удирдлагын хэлтэс болон Статистикийн нэгдсэн сан /1212.mn/-аас буюу хоёрдогч эх үүсвэрээс судалгааны өгөгдөл буюу дата мэдээллийг цуглуулсан. Судалгааг тоон болон чанарын аргаар судалгааг боловсруулав.

Олон улсын автотээврийн холбоо (IRU) нь 2016 оны бага хурлыг “Ухаалаг хот ба нийтийн тээвэр” сэдвээр зохион байгуулсан ба тоглоомын онолын схемд үндэслэн боловсруулсан “Замын хөдөлгөөний динамик /Dynamic Mobility Traffic (DMT) model/” хэмээх математик загварыг өөрийн гишүүн орнуудад ашиглахыг санал болгосон. Энэхүү математик загварын гол зорилго нь одоогийн нөхцөл байдлыг загварчилж, энэ нөхцөл байдал дахь боломжит үйлдлүүдийн дундаас хамгийн тохиромжтой арга замыг олоход оршино.

Судалгаа шинжилгээний үндсэн дээр батлагдсан хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн дараах аргуудыг Европын улс орнууд өргөнөөр ашигладаг байна. Тухайлбал хот хоорондын зорчигч тээврийн системийн үйл ажиллагаа тогтвортой хангагдсан байгаа тохиолдолд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин өндөр байх бөгөөд зорчих эрэлт их байна хэмээн үзээд Чех улсын судалгааны хүрээлэнгээс “Factor”-ын загварыг боловсруулсан байна. Энэхүү загварыг анх Чех улсад туршиж үзсэн бөгөөд Европын улс орнууд өргөнөөр ашиглаж байна. Зорчигчдын сэтгэл ханамжид тээврийн тогтмол байдал, хүлээх хугацаа, аяллын хүртээмж, аюулгүй байдал, тав тухтай байдал, тасалбарын үнэ зэрэг хүчин зүйлүүд голлон нөлөөлдөг байна. Зорчигч урсгалын хэмжээг зорчигчдын сэтгэл ханамжийн түвшинд тулгуурлан тооцохын тулд нөлөөлж буй хүчин зүйлсийг тоон үзүүлэлтээр тодорхойлж нэгдсэн загвар боловсруулах шаардлагатай байдаг. Мөн хот хоорондын зорчигчдын урсгал хөдөлгөөнд бүс нутгийн эдийн засгийн хөгжил мөн нөлөөлж байдаг. Тиймээс Ньютоны таталцлын загвар дээр үндэслэн хот хоорондын зорчигч урсгалын таталцлын дараах зохицсон загварыг гаргасан.

Судалгааны ажилд редакцийн санал, шүүмж авахаар 2022 оны 1/832 тоот албан бичгээр эхний шатны тайланд ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Үйлдвэрийн газрын ажилтнууд болон үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа.



Үйлдвэрийн газрын ажил үйлчилгээг авч буй үйлчлүүлэгч болон үйлдвэрийн газрын ажилтан албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах зорилгоор энэхүү судалгааг хэрэгжүүлсэн. Удирдамжийн дагуу 2022.03.05-15-ний өдрийг дуустал 10 хоногийн хугацаанд

<https://docs.google.com/forms/> ашиглан онлайн хэлбэрээр зохион байгуулж нийт

327 ажилтан, 348 үйлчлүүлэгч хамрагдсан. Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-аар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн индекс дундаас дээгүүр (6-7.9) байна. Иймд бид үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг жилд нэг удаа бус тогтмол хийж хангалтгүй үнэлгээ авсан үйл ажиллагааны чиглэлээр тухай бүр тодорхой ажил сайжруулах төлөвлөгөө гарган үйлчилгээний чанарыг байнга сайжруулж ажиллах шаардлагатай байна.

7.2. Чанарын дэд бүтцийн чиглэлээр

Тайлант хугацаанд нийт 17 иргэн, ААН тохирлын үнэлгээ хийлгэх өргөдөл ирүүлсэн ба ирсэн өргөдөл, холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийж, баталгаажуулалтын үнэлгээг хийх боломжтой 12 иргэн, ААН -ийн үйлчилгээнд баталгаажуулалтын үнэлгээг хийсэн. 2022 оны эхний хагас жилд нийт 16 иргэн, ААНБ-д тохирлын гэрчилгээ олгосон байна.

Лаборатори нь автотээврийн салбарт ашиглагдаж байгаа 9 төрлийн 108 ширхэг хэмжих хэрэгсэлд олон улсын нэгжийн СИ системийн дагуу нэгж дамжуулах, шалгалт, тохируулга хийж гэрчилгээ олгосон байна.

Хүсэлт ирүүлсэн 9 ААНБ-ийн 36 ширхэг хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийж 750.700 төгрөгийг үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлсэн.

Автотээврийн салбарын стандартчиллын техникийн хороо /ТХ-15/-ны 2022.03.04-ний өдрийн хуралдаанаар дараах стандартуудыг хэлэлцүүлж батлуулсан. Үүнд:

1. MNS 6969:2022Тээврийн хэрэгслийн резин дугуй засварын үйлчилгээ. Ерөнхий шаардлага.
2. MNS 6970:2022 Автотээврийн хэрэгслийн их биеийн засвар, үйлчилгээ. Ерөнхий шаардлага
3. MNS 6971:2022 Автотээврийн хэрэгслийг тос, тосолгооны болон ашиглалтын материалаар цэнэглэх үйлчилгээ. Ерөнхий шаардлага.

Үйлдвэрийн газраас үзүүлж буй үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд зөв боловсон, хурдан шуурхай, шударга, тэгш хүртээмжтэй, чанартай хүргэх зорилгоор байгууллагын “Үйлчилгээний стандарт” боловсруулан батлуулсан. Энэхүү стандарт нь бидний үйл ажиллагаандаа баримтлах зарчим, соёл, гадаад төрх, ажлын байранд тавигдах шаардлага,



Өдөрлөгт “Health and safety Solutions” ХХК-ийн гүйцэтгэх захирал, АУ-ны доктор Д.Нарансүх “Аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн эрүүл мэндийн үндсэн үйл ажиллагаа” сэдвээр илтгэл тавьж, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилтийн багаж хэрэгслийн талаар танилцуулсан.

ХНХЯ-ны харьяа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний төвөөс ХАБЭА-н нийт ажилтны болон ажил олгогчийн сургалт явуулах эрхийг тус үйлдвэрийн газар 2019 онд авснаас хойш давхардсан тоогоор нийт 46 удаагийн танхимийн болон онлайн хосолсон сургалт зохион байгуулаад байна. 2022 онд үйлдвэрийн хэмжээнд 14 удаагийн сургалт зохион байгуулж нийт 320 ажилтан албан хаагчдыг хамруулж шалгалтад тэнцсэн 316 ажилтанд гэрчилгээ олгосон.



ХАБЭА-н нийт ажилтны болон ажил олгогчийн сургалт явуулах ажлын хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж, осол ба гэнэтийн аюулын үед ямар арга хэмжээ авч ажиллах талаар мэдээллийг агуулсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар ажилтнуудад зориулсан гарын авлага”-ыг нийт ажилтнуудын өдөр тутмын ажлын хэрэгцээнд зориулан боловсруулсан болно.

НАЙМ. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР

8.1 Програм хангамжийн хөгжүүлэлтийн талаар

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмд нотариатын сервис холбох

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмд нотариатын сервис холбож дууссан. Уг сервисийг холбосноор иргэн гэрээний материал цаасаар авчирах шаардлагагүй болсон бөгөөд тухайн иргэнтэй хийсэн гэрээг цахимаар солилцдог болсон. Мөн бүртгэлийн мэргэжилтний ажлын үр бүтээмжийн дээшлүүлж аливаа хуурамч бичиг баримт, залилангаас хамгаалах үр ашигтай ажил болсон. Програмчлалын хувьд нотариатын сервистэй холбогдсоноор цахим маягт дээр тухайн А-тал, Б-талын мэдээллийг бүртгэлийн цахим архивд давхар хадгалж PDF форматаар автоматаар хадгалж архивладаг болсон.

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн цахим хүсэлт

Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийхэд шаардлагатай сервис солилцох тоон гарын үсгээр баталгаажсан албан хүсэлтийг хүлээн авч, гэрчилгээний төлбөрийг цахимаар гүйцэтгэх боломжийг бүрдүүллээ. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн VRS систем дээр цахим хүсэлтийн хөгжүүлэлтийг бүрэн хийж дуусгав. Дээрх цахим хүсэлт нэвтрүүлэхтэй холбоотой журмын төслийг ТХБХ боловсруулан ажиллаж байна.

е-Монгол портал болон бусад төрлийн интерфэйсүүдээр дамжуулан хүргэх боломжийг бүрдүүлэх

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмд нотариатын сервис холбосонтой холбогдуулан И-Монгол порталд тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээнд эзэмшигч таних

гэрээ хэлэлцээр баталгаажуулан шилжилт хөдөлгөөнд нэвтрүүлээд байна. 2022.06.20-ний өдрийн байдлаар И-Монгол порталаар дамжуулж уг үйлчилгээг аваагүй байна.

Үйлдвэрийн газрын МТХ-ийн дарга Нэргүй, ТЦА-ны ХМТХ-ийн дарга х/а Баттулга, И-Монгол академийн мэргэжилтэн Мөнхтулга нартай уулзаж ЗГХЭГ-ын даргын 2019 оны 84 дүгээр тушаалаар баталсан журмыг судлан үзсэний үндсэн дээр “e-mongolia” цахим үйлчилгээнд ашиглаж буй “Төрийн мэдээллийн сангаас гарах лавлагаа, тодорхойлолтын нэгдсэн маягт”-ыг нэвтрүүлэх саналыг хэлэлцэж 2022.03.21-ний өдрийн 2/361 тоот албан бичгээр И-Монгол академид хүсэлт хүргүүлсэн.


Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагаанд тоон гарын үсгийг нэвтрүүлэх чиглэлээр

2022.05.01-ний өдрөөс цахим гарын үсгийн тухай хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан “Үндэсний Дата Төв” УТҮГ-тай тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, хамтран ажиллах гэрээ байгуулан зохих албан тушаалтнуудад нийт 125 ширхэг тоон гарын үсгийн гэрчилгээг олгосон цаашид 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд техникийн хяналтын хэлтсийн мэргэжилтэн албан хаагчдыг тоон гарын үсэг олгохоор төлөвлөн ажиллаж байна. Архив, албан хэрэгт хөтлөлт, бичиг хэргийн хөтлөлт хариуцсан мэргэжилтэнд тоон гарын үсэг олгосон.

Банк, банк бус ААН-үүдтэй тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний хүсэлтийг цахим гарын үсгээр баталгаажуулж хүлээн авах програм хангамжийг амжилттай нэвтрүүлж дуусгасан. “InvesCore” ХХК-тай хамтран ажиллах албан ёсны гэрээ байгуулахыг хүлээж байна. Мөн MNS 5140:2011 стандарт болон сүүлд шинээр нэвтэрсэн албан бичиг хэрэг хөтлөлтийн шинэ програм хангамжуудыг судлах судалгааны ажил хийгдэж байна

Дотоодын ачаа тээврийн цахим системийн гар утсанд зориулсан хувилбар

Дотоодын ачаа тээврийн цахим системийн мобайл апп хөгжүүлэлтийг Андроид болон IOS үйлдлийн системд зориулан хийж гүйцэтгэж дууслаа. Хэрэглэхэд ойлгомжтой энгийн, тээвэрлэгч



болон ачаа илгээгчийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулсан хилийн боомтуудаар тээвэрлэлт гүйцэтгэх дугаарлалтыг ил тод нээлттэй болгон үйлдвэрийн газрын бусад системүүдтэй мэдээлэл солилцон ажиллах юм.


Андройд гар утсанд зориулагдсан хувилбар google playStore, IOS үйлдлийн системтэй гар утас болох iphone-д зориулагдсан хувилбар AppStore-д байршуулав.

Зорчигч тээвэрлэлт-Онлайн тасалбар борлуулалтын системийг хөгжүүлэх

<https://service.transdep.mn/> дундын мэдээллийн систем дээр нээлттэй сервисийг байршуулж олон нийтэд зарласан. 2022 оны 1-р улирлын байдлаар 1235 захиалгыг уг нээлттэй сервисээр дамжуулан хүлээн авсан байна. Уг сервисийг авч ашиглахаар холбогдож ажиллаж байгаа системүүдээс дурдвал Taratrip, SocialPay, iTrip, SkyTicket г.м.

Байгууллагын албан ёсны цахим хуудас transdep.mn

Байгууллагын үндсэн вэбийг шинэчлэх үүрэг даалгаврын хүрээнд: Вэбийн бүтэц, дизайн болон мэдээллийн агуулгыг тодорхойлон, ЗСХНХ-ээс шаардлагатай зургийн санг авч систем хөгжүүлэлтийн ажлыг 2022.04.23-нд хийж гүйцэтгэсэн байна.



8.2 Сервер, сүлжээ ашиглалтын чиглэлээр

Хийсвэр серверүүдийг кластер руу шилжүүлэх ажлыг 2 үндсэн шаттай хэрэгжүүлсэн.

1. VMware HA cluster тохируулах, суурилуулах
 - VMware vCenter суулгаж тохируулах, лицензжүүлэх
 - Host-уудыг холбох, HA cluster тохируулах
 - Хийсвэр серверүүдийг HA cluster руу шилжүүлэх
2. Standalone серверүүдийг цэгцэлж ЗТХЯ-нд сервер гаргаж өгөх
 - А болон Б зааланд байсан Dell PowerEdge R730 маркийн серверийг хооронд нь сольж байршуулсан. Ингэснээр манай байгууллагын ашиглаж байгаа серверүүд нэг зогсуурт бүгд байршиж байна.
 - А зааланд байршуулсан серверийг ЗТХЯ түр хугацаагаар ашиглуулахаар хаяглалт болон хандалтын эрхийг тохируулж өгсөн.

- Б зааланд шилжин ирсэн Wialon Local GPS системийг түр хугацаанд Qnap NAS storage рүү шилжүүлэх

Дээрх өөрчлөлтийн хийсний дараа дараах бүтэцтэй болсон байна.

- VMware HA cluster - 3ш host server, 1ш storage;
- Standalone - 2ш сервер, 1ш NAS;

Хийсвэр серверүүдийн нөөц тохируулах

Hyper Data protector ашиглан хийсвэр серверүүдийг Qnap NAS серверт incremental backup хийх ажлыг дуусгасан байна. Нийт 10ш хийсвэр сервер байгаад бөгөөд мэдээллийн чухал байдлаасаа шалтгаалан 1-5 хоног давтамжтай нөөцлөлт хийж байна.

8.3 Компьютер, техник хангамжийн чиглэлээр

ERP системд 2022 оны 1 дүгээр сараас ирсэн нийт захиалга 756 ирсэн. Үүнд орон нутаг дахь Автотээврийн төвүүдийн зайн хандалтын програм хангамжийг ашиглаж /TEAMVIEWER/ принтер, TTS, MVIS болон бусад шаардлагатай програм хангамжуудын тохиргоо, хэрэглээний програм хангамжуудыг шинээр суулгаж, зааварчилга өгч ажиллалаа.

Орон нутгаас ирсэн компьютер, принтерүүдийг цаг тухай бүрд нь засварлаж, шаардлагатай техник хэрэгслийн сэлбэг хэрэгслээр сольж форматалж, буцаан орон нутаг руу явуулан ажиллаа.

2021 оны тендер худалдан авсан компьютер техник хэрэгсэлд систем суулгаж хэрэглээний програм хангамжуудыг тохируулж хийж гүйцэтгэлээ.

Цахим онлайн хурал, сургалт бусад хэлтэс, тасгуудтай хамтран ажиллаж. ZOOM програмыг ашиглаж оролцсон.

22 -ын хяналтын пост байрлах дээр урсдаг лед дэлгэцийг тогтоож, програм хангамжийг шинэ суулган зааварчилгаа өгч ажиллалаа. Мөн СХЗТТ-ын компьютер техник хэрэгслүүдийг хуваарийн дагуу явж засвар үйлчилгээ хийж, шаардлагатай компьютерүүдийг нь форматалж хэвийн ажиллагаатай болгосон. Принтерын засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэлээ.

Мэргэшсэн жолоочийн тасгийн 20 ширхэг шинэ компьютер авсантай холбогдуулсан програмын тохиргоо, шаардлагатай компьютер техник хэрэгслийг форматалж хэрэглээний програм хангамжуудыг суулгах, Принтер, програмын тохиргоог хийж гүйцэтгэлээ.

Баянгол техникийн хяналтын үзлэг нь нүүж Мастер плаза дээр байрласантай холбогдуулан хяналтын камеруудыг шинээр суулгасан, Мөн дотоод сүлжээний зохион байгуулалтыг хийж гүйцэтгэсэн.

Сонгинохайрхан техникийн үзлэгийн байранд баянгол техникийн үзлэгийн 1 шугам байрласантай холбогдуулж дотоод сүлжээний зохион байгуулалтыг шинээр хийж гүйцэтгэсэн. Мөн хяналтын камеруудын тохиргоог хийж гүйцэтгэсэн.

Судалгаа хөгжил чанарын удирдлагын төвийн мэргэжилтнүүд Сонгинохайрхан салбарын лабраоторын өрөөндөө байрлахтай холбогдуулан дотоод сүлжээний утсыг шинээр зохион байгуулж сүлжээтэй болгосон.

Орон нутгийн инженер, бүртгэлийн мэргэжилтнүүд сумдаар ажиллахтай холбогдуулж зөөврийн компьютерүүдэд гэрчилгээ хэвлэгч принтер, техникийн хяналт үзлэгийн програм хангамжийн тохиргоо, шинээр суулгах шаардлагатай програм хангамжуудыг хийж гүйцэтгэлээ.

Гэрээтэй тээвэр компаниудын компьютерүүдэд TTS програм хангамжуудыг шинээр суулгаж хийж гүйцэтгэлээ.

8.4 Салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр

Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөр 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд:

Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын 4 дэх заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID/-г урьдчилан бэлтгэх, тээврийн хэрэгсэлд

байрлуулах, бүртгэх үйл ажиллагааны 2022 оны нарийвчилсан төлөвлөгөө"-ний санал авах бичиг 2022.02.18-ны өдрийн 04/728 тоотой ирүүлсэн бөгөөд санал хүргүүлэн хамтран ажиллаж байна. Цахимжуулах 2022 оны төлөвлөгөө ЗТХЯ-наас эцэслэн батлагдаагүй байна.

ЕС. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭ

Хяналт-шинжилгээ, дотоод аудитын албанаас 2022 онд 4 зорилтын хүрээнд 34 гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлуулан, 2022 оны эхний хагас жилийн байдлаар доорх ажлуудыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

9.1 Дотоод аудитын талаар

Үйлдвэрийн газрын захирлын баталсан удирдамжийн дагуу 2022.03.23-ны өдрөөс 2022.04.01-ний өдрүүдэд “Мэргэшсэн жолоочийн сургалтын тасаг”-т, 2022.05.03-05 өдрүүдэд “Сонгинохайрхан зорчигч тээврийн төв”-д, 2022.06.06-08-ны өдрүүдэд “Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төв”-д төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус санхүүгийн аудитыг гүйцэтгэлээ. Шалгалтын явцад НББ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог үндэслэл болно." заалтыг мөрдөн ажиллах, Нягтлан бодогч, нярав нарын хоорондын ажлын уялдааг сайжруулах, санхүүгийн анхан шатны баримт, агуулахын бүртгэл хөтлөлтөд анхаарах, үнэт цаасыг дугаарын дагуу тухай бүр нь хяналт тавьж гарын үсэг зурж байх, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” гэсэн заалтуудыг мөрдөж ажилладаггүй зэрэг нийтлэг алдаа дутагдлууд гарсан бөгөөд нийт 9 зөвлөмжийн хэрэгжилтийг сарын хугацаанд ирүүлэн алдаа дутагдлаа сайжруулан ажиллахыг зөвлөн ажиллалаа.

9.2 Шилэн дансны тухай хуульд заасан стандартын дагуу байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн талаар:

Шилэн дансны мэдээлэл байршуулах эрх бүхий албан тушаалтнуудад дотоод сүлжээгээр болон утсаар холбогдон тогтмол анхааруулга зөвлөмж өгч, явцын мэдээг Захиралд танилцуулан ажиллаж байна. 2022 оны 1 дүгээр улирлын тайланг Сангийн яаманд цахимаар, Зам, тээврийн хөгжлийн яаманд 2022.04.07-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн. 2022 оны эхний 5 сарын байдлаар тус үйлдвэрийн газрын хэмжээнд нийт мэдээллэх - **1683** мэдээлэл байна. Үүнээс:

- Хугацаандаа мэдээлсэн – **1645**
- Хугацаа хоцроож мэдээлсэн – **38**

9.3 Дотоод хяналт шалгалтын талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хүрээнд дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг ХШДАА болон салбар төвүүд тус бүрт батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд 2022 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч зөвлөмж өгөхөөр ажиллаж байна. Мөн тус албанд 2022 оны эхний хагас жилийн байдлаар дотоод хяналт шалгалтын хүрээний 9 өргөдөл гомдол ирснийг холбогдох журмын хүрээнд хяналт шалгалт хийж, хариуг тухай бүр хүргүүлэн ажиллалаа.

Үйлдвэрийн газрын захирлын баталсан удирдамжийн дагуу 2022.03.23-ны өдрөөс 2022.04.01-ний өдрүүдэд “Мэргэшсэн жолоочийн сургалтын тасаг”-т, 2022.05.03-05-ны өдрийг дуустал “Сонгинохайрхан зорчигч тээврийн төв”-д, 2022.06.06-08-ны өдрүүдэд “Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төв”-д төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг холбогдох журмын хүрээнд хийж гүйцэтгэн тайланг танилцуулан үүсэж болзошгүй эрсдэл болон нийтлэг илэрч буй зөрчлүүдэд зөвлөмж зөвлөгөө өгч ажиллалаа.

9.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар

Үйлдвэрийн газрын хэмжээнд 2022.06.20-ны байдлаар нийт-42 албан томилолт хийгдсэнээс “бүрэн хэрэгжсэн”-39 “хэрэгжих шатанд”-2, “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-1 үнэлгээний дундажаар 90 хувийн үнэлгээтэй байна.

Үйлдвэрийн газрын бүтцийн нэгжүүдийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд улирал, хагас жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад танилцуулж, дүнгийн дагуу санал зөвлөмжийг нэгжийн удирдлага, ажилтанд захидлаар хүргүүлэхээр ажиллаж байна. Хэлтэс, тасаг, Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв, Улаанбаатар хот дахь зорчигч тээвэр, техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн албан бичгийн шийдвэрлэлтийн тоон мэдээг Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтсийн Албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн ирүүлсний дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, албан бичгийн шийдвэрлэлтийн хугацаа хэтрүүлсэн нэгжүүдэд анхаарч ажиллах талаар санал зөвлөмж өгч, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Үйлдвэрийн газрын захирлын тушаалын хэрэгжилтэд сар бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, захиралд танилцуулан ажиллаж байна. Үүнд:

- 2022 оны 01 дүгээр сарын тушаалын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “Бүрэн хэрэгжсэн”-58, “Хэрэгжих шатанд”-21, гүйцэтгэлийн үр дүн 92 хувь байна. Удаашралтай хэрэгжиж буй тушаалын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “Бүрэн хэрэгжсэн”-7, “Хэрэгжих шатанд”-18, гүйцэтгэлийн үр дүн 78,4 хувь байна.
- 2022 оны 02 дугаар сарын тушаалын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “Бүрэн хэрэгжсэн”-49, “Хэрэгжих шатанд”-2, гүйцэтгэлийн үр дүн 96,9 хувь байна.
- 2022 оны 3 дугаар сарын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “Бүрэн хэрэгжсэн”-87, “Хэрэгжих шатанд”-6, гүйцэтгэлийн үр дүн 98 хувь байна.
- 2022 оны 4 дүгээр сарын тушаалын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “Бүрэн хэрэгжсэн”-75, “Хэрэгжих шатанд”-1, “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-9, гүйцэтгэлийн үр дүн 99,6 хувь байна.
- Захирлын 2020 оны 02, 3, 7, 8, 2021 оны 02, 3, 5, 6, 7, 10, 11, 12, 2022 оны 01, 02, 3 дугаар сард өгсөн удаашралтай хэрэгжиж буй тушаалын биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг 2022.05.19-ний өдөр танилцуулсан. Захирлын тушаалын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “Бүрэн хэрэгжсэн”-8, “Хэрэгжих шатанд”-29, “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.”-1, гүйцэтгэлийн үр дүн 76,4 хувь байна.

Үйлдвэрийн газрын захирлын баталсан удирдамжийн дагуу “Сонгинохайрхан зорчигч тээврийн болон техникийн хяналтын үзлэгийн төв”-д төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус санхүүгийн аудит болон дотоод хяналт шалгалтыг хийх удирдамжийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, захирлын тушаал, өргөтгөсөн шуурхай зөвлөгөөнөөс нэгжийн удирдлагад өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төвд ирүүлсэн санал хүсэлт, гомдлын шийдвэрлэлтийн байдалтай газар дээр нь танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, тайланг удирдлагад танилцуулж ажиллав.

8.5 Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажиллах талаар

2022 оны эхний хагас жилийн байдлаар үйлдвэрийн газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийхэд нийт-219 өргөдөл гомдлоос Бүрэн хэрэгжсэн-214, Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй-5, үнэлгээний дундажаар 92 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мөн тайлант хугацаанд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол -75, Ажилтан албан хаагчдаас-144 өргөдөл гомдол ирснийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. Өргөдөл гомдлын зонхилох хувь нь чөлөө тэтгэмж хүсэх тухай-20, ажлаас чөлөөлөгдөх тухай-19, ажилд томилуулах тухай-17, техникийн дүгнэлт гаргуулах тухай-16, хүсэлт гаргах тухай-34 бусад өргөдөл-113 эзэлж байна.

“Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв”-д 2022.06.20-ний өдрийн байдлаар тус үйлдвэрийн газрын нэр дээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт санал хүсэлт, өргөдөл, гомдол-112 ирсэн ба 103-г санал хүсэлт, өргөдөл, гомдлын хариуг шийдвэрлэж, ЗТХЯ-нд хүргүүлсэн. Шийдвэрлэх шатанд 9 гомдол хяналтад байна.

2022.06.11-ний өдрөөс эхлэн Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан гомдол, санал хүсэлтийн 70071234 дугаар утсанд дуудлага авч эхэлсэн. Тухайн хугацаанд нийт-48 гомдол ирсэнийг тухай бүр нь холбогдох хэлтэс нэгж, салбарт шилжүүлэн тухайн гомдол гаргасан иргэнтэй холбогдон хариуг өгч шийдвэрлэн тухай бүр захиралд танилцуулан ажиллаж байна.

АРАВ. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГЛЭЛЭЭР

10.1 Нягтлан бодох бүртгэл

Санхүүгийн тайлан: Үйлдвэрийн газрын 2021 оны 4-р улирлын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж, хуулийн хугацаанд Нийслэлийн төрийн санд баталгаажуулж, татварын тайланг хуулийн хугацаанд буюу 2022.02.20-нд Нийслэлийн болон Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст цахимаар баталгаажуулан ажилласан. 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтэд өгөгдсөн 1 акт, 23 зөвлөмж, 7 албан шаардлагын дагуу төлөвлөгөө боловсруулан удирдлагаар батлуулан салбар төв, хэлтэс, албадуудад хүргүүлсэн. Биелэлтийг хугацаанд нь ҮАГ, ЗТХЯ, ТӨБЗГ-т тус тус хүргүүлэхээр ажиллаж байна.

Цалин хөлс: 2022 оны эхний хагас жилийн байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр үндсэн цалинд 5.9 тэрбум төгрөг олгож, 868.3 сая төгрөгийг НДШ-ийн зардалд төлөхөөр байна. Сар бүр НДШ-ийн тайланг цахим болон цаасан хэлбэрээр шивж хариуцсан байцаагч руу илгээж баталгаажуулсан. Мөн ХХОАТ-ын тайланг гаргаж 375,7 сая төгрөгийг Татварын газарт шилжүүлсэн ба баланс тайлан гарахад 10-15 сая төгрөгийн ХХОАТ-ын зөрүүг нэмж тайлагнахаар тооцлоо. Хуулийн хугацаанд нь etax сайтруу илгээнэ.

Мэргэшсэн жолоочийн орлого: 2022 оны 2-р улирлын байдлаар өссөн дүнгээр 29635 хүн шалгалт өгч, нийт 263.6 сая төгрөгийн, мэргэшсэн жолоочийн үнэмлэх 7431 ширхэг хэвлэгдэж 82.7 сая төгрөгийн орлогын тайлан хүлээн авч программд бүртгэл хөтөлсөн байна.

Шатахуун : 2022 оны 2-р улирлын байдлаар төв албанд өссөн дүнгээр шатахуунд 44,9 сая төгрөгийн норм батлуулж төсвийн дагуу олгогдсон бөгөөд 40,4 сая төгрөгийн гүйцэтгэлийн тайлан хүлээн авч программд бүртгэл хөтөлсөн байна. Орон нутгийн салбар төвүүдэд шатахууны санхүүжилтээр 90.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба нийт хүлээгдэж буй гүйцэтгэлээр эхний хагас жилд 150.9 сая төгрөгийн шатахууныг зарцуулахаар тооцооллоо.

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн орлого : 2022.06.20-ны байдлаар бүртгэлийн үйлчилгээний орлого 2,760 сая төгрөг, лавлагааны орлого 18.1 сая төгрөг, Гэрчилгээний орлого 106.2 сая төгрөгийн орлогыг бүртгэж, Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст Улсын тэмдэгтийн хураамж 680.9 сая төгрөгийг төвлөрүүлэхээр байна. 2022.06.20-ны байдлаар төвийн салбаруудад нийт 255,800 ширхэг гэрчилгээ олгож 205,480 гэрчилгээний зарцуулалтын тайлан хүлээж авсан. Хөдөө орон нутагт 59,600 ширхэг гэрчилгээ олгож 51,110 ширхэг гэрчилгээний зарцуулалтын тайлан тус тус хүлээж авсан. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр тээврийн хэрэгслийн бүртгэлийн орлого 3.5 тэрбум төгрөг хүрч орлогын төлөвлөгөөг 44%-иар давуулан биелүүлэхээр ажиллаж байна.

Касс орлого, зарлага: Өдөр бүр төв албаны кассын орлого, зарлагын гүйлгээг санхүүгийн програмд шивж кассын орлогын 45.99 сая төгрөг, зарлагын 55.5 сая төгрөг, зарлагын харилцах дансан дахь орлогын 12.174.4 сая төгрөг, зарлагын 10.942.3 сая төгрөгийн гүйлгээг шивж холбогдох дансуудад нь бичилтийг хийж ажилласан. Сар бүр кассын үлдэгдлийг тоолж, бэлэн мөнгөний тооллогын бүртгэл хийж баталгаажуулсан. Харилцахын хуулгыг хэвлэн авч сар бүр

банкны диллэрээр үлдэгдлийг баталгаажуулж ажилласан. Томилолтоор ажилласан ажилтнуудаас 50.39 сая төгрөгийн томилолтын тооцоог хүлээн авч баримтын бүрдлийг хангуулж, холбогдох зардлын дансанд бичилтийг хийсэн.

Даатгал: 10 хоног тутамд зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлж байгаа 25 салбар төвүүдийн төвлөрүүлсэн даатгалын тооцоог харилцагч даатгалын байгууллагуудтай нийлж, зорчигч тээврийн амь даатгалын тооцоог “Нэйшнл Эженси” ХХК-тай гэрээнд заасан хугацаанд тооцоо нийлж 608.95 сая төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн. 2022 оны 2 дугаар улирлын салбар хоорондын тооцоог нийлсэн.

Бараа материал: 2022 оны II дугаар улирлын байдлаар маягт үнэт цаасны 106.0 сая төгрөгийн орлого, 42.5 сая төгрөгийн зарлагын гүйлгээ болон агуулах хоорондын 308.6 сая төгрөгийн гүйлгээ хийсэн. Бичиг хэргийн материалын 88.4 сая төгрөгийн орлого, 79.1 сая төгрөгийн зарлага гүйлгээ хийж ажилласан. Бараа материалын 43.1 сая төгрөгийн орлого, 81.6 сая төгрөгийн зарлага болон 31,9 сая төгрөгийн агуулах хоорондын гүйлгээ хийсэн, сэлбэг хэрэгслийн 42.4 сая төгрөгийн орлого, 3.9 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус хийсэн.

Үндсэн хөрөнгө: 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 510.3 сая төгрөгийн орлогын гүйлгээ болон салбарт 448.5 сая төгрөгийн зарлагын гүйлгээ болон агуулах хоорондын 307.1 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Авлага: Нийт авлагын дүн 2021 оны жилийн эцсийн байдлаар 99,8 сая төгрөг байснаас 2022 оны 2-р улирлын байдлаар 376 сая төгрөг болж 276,2 төгрөгөөр өссөн байна. Татварын авлага: 2021 оны жилийн эцсийн байдлаар 30,8 мянган төгрөг байснаас 2022 оны эхний хагас жилийн байдлаар 175 сая төгрөг болж өссөн байна.

Богино хугацаат өр төлбөр: 2022 оны 1-р улирлын байдлаар богино хугацаат нийт өр 566.1 сая төгрөг байснаас 2022.06.20-ны байдлаар 1,412 сая төгрөг болж өссөн байна.

Урт хугацаат өр төлбөрийн дүн: 2022 оны хагас жилд урт хугацаат зээл буюу Нордикийн үндсэн зээлийн төлбөрт 59 988 SDR буюу 250,1 сая төгрөг, хүүгийн төлбөрт 6 598.83 буюу 27,5 сая төгрөг төлөхөөр тооцоолон ажиллаж байна.

Агуулахын үндсэн хөрөнгө: Тайлант хугацаанд маягт үнэт цаасны 3,4 сая төгрөгийн орлого, 72,5 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн. Бичиг хэргийн материалын 45.0 сая төгрөгийн орлого, 26.2 сая төгрөгийн зарлага гаргаж ажилласан. Бараа материалын 7.5 сая төгрөгийн орлого, 65.2 сая төгрөгийн зарлага, сэлбэг хэрэгслийн 24.7 сая төгрөгийн орлого, 4.9 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус хийсэн. Мөн эхний хагас жилийн байдлаар нийт 162,3 сая төгрөгийн орлогын гүйлгээ болон 123.0 сая төгрөгийн зарлагын дотоод хөдөлгөөн, шилжилтийн гүйлгээг хийсэн. Ашиглалтанд байгаа хангамжийн материал: 2022 оны 2-р улирлын байдлаар 60 ширхэг 12.6 сая төгрөг байна.

Улс, хот хоорондын ачаа тээврийн үйлчилгээ, GPS-тэй холбоотой орлого: Тайлант хугацаанд өссөн дүнгээр 879,9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажилласан байна. Үүнээс GPS-ийн орлого 738,3 сая төг, лавлах үйлчилгээ буюу тусгай дугаарын орлого 140,8 сая төг, GPS-ийн суурилуулалт, салгалтын орлого 830,0 мян төг. Улс, хот хоорондын байнгын ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч 220 ААНБ-ыг бүртгэгдсэн.

Тээврийн хэрэгслийн улсын дугаарын дуудлага худалдаа: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020.11.18-ны өдрийн А/222 дугаар тушаалаар “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг шинэчлэн баталсан. Үүнтэй холбогдуулан “АТҮТ” ТӨҮГ-ын захирлын 2020.12.08-ны өдрийн А/287 дугаар тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг дуудлага худалдаагаар зохион байгуулах удирдамж”- ийн дагуу тус үйлдвэрийн газрын дуудлага худалдааны дансанд тээврийн хэрэгслийн улсын дугаарын

дуудлага худалдааны дэнчингийн орлогыг төвлөрүүлж, 2022 оны 2-р улирлын байдлаар нийт 600 ширхэг дугаарын 1,2 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, буцаалт хийгдэх нийт 6100 иргэний 305,000,000 төгрөгийн дэнчин төвлөрсөнөөс, хаан банкны 5500 иргэний 275,000,000 төгрөг, банк хооронд 600 иргэний 30,000,000 төгрөгийн дүнтэй дэнчинг буцаан олгосон. Эхний хагас жилийн байдлаар улсын дугаарын дуудлага худалдаанаас төвлөрсөн 500.0 сая төгрөгийг 2022.04.27-ны өдөр “Хүүхдийн төлөө” тусгай санд шилжүүлсэн. Тайлан баланс эцэслэхэд үлдэгдэл 500.0 сая төгрөгийг тусгай санд төвлөрүүлэхээр тооцоолон ажиллаж байна. Тээврийн хэрэгслийн улсын дугаарын дуудлага худалдааны мэдээллийг өдөр бүр 09.00, 14.00, 16.00 цагт тайлагнаж ажилласан.

Татвар: НӨАТ-ын тайланг хуулийн хугацаанд Нийслэлийн татварын газарт илгээж 2022 оны 2-р улирлаар 886 сая төгрөгийн ногдолыг төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажилласан байна. ААНОАТатварын тайланг хуулийн хугацаанд нийслэлийн татварын газарт илгээж 2-р улирлаар 55,4 сая төгрөгийн ногдолыг төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажилласан байна.

10.2 Эдийн засгийн чиглэлээр хийгдсэн ажлууд

2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин 2021.12.23-ны өдрийн 682 дугаар тогтоолоор батлагдсан. Зорилтот түвшинд батлагдсан төсвийг төв болон салбарт орлогыг сар жилээр хуваарь хийж 2022.01.24-ний өдөр батлуулан, зардлыг сар жилээр хуваарь хийж 2022.05.19-ны өдөр батлуулсан ба салбар төвүүдэд хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үйлдвэрийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд балансад аудит гүйцэтгэхэд, СЯ, ЗТХЯ-ны хамтарсан шалгалтад тус тус шаардлагатай материалыг бэлтгэн хүргүүлсэн. Үйлдвэрийн газрын захирлын ажил хариуцуулан гүйцэтгэх гэрээ, Контрактын гэрээнүүдийг амжилттай дүгнүүлсэн. Харьяа дээд шатны байгууллагуудад цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Цаг үеийн нөхцөл байдлаар энэ онд нийт орон нутгийн томилолт 54 удаагийн 80.2 сая төгрөг /нийт томилолтын 28% нь Өмнөговь аймгийн Цогтцэций салбар, Гашуунсухайт, Цагаанхад боомтод ажилласан томилолт бол, 17% нь Дорноговь аймгийн Замын-Үүд, Ханги боотмуудад ажилласан төсөв байна/, гадаад томилолт 1 удаагийн 17.4 сая төгрөг, шатахууны 7 удаагийн 6.4 сая төгрөг, сэлбэг 6 удаагийн 22.4 сая төгрөг, зөвлөгөөн, сургалт зохион байгуулахад 1 удаагийн 47.8 сая төгрөг, гэрэл цахилгааны засварт 1 удаагийн 5.6 сая төгрөг, урсгал засварт 5 удаагийн 10.7 сая төгрөг, бусад 5 удаагийн 12.5 сая төгрөгийн төсвийг тус тус батлуулан зарцуулсан байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар орон нутгийн салбар, төвүүдэд нийт 6 удаагийн санхүүжилтээр 6.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлж, тухай бүрд дансны үлдэгдлийг хянаж шаардлагатай зардлыг үлдээх, илүүдэл санхүүжилтийг татан авах ажлыг зохион байгуулсан.

9.3 Орлого, зардал, ашиг алдагдал:

Орлого: 2022 оны эхний хагас жилд нийт 15.0 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллахаар төлөвлөснөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 16.2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж 108%-ийн биелэлттэй 1.2 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлэхээр тооцооллоо. Жилийн орлогын төлөвлөгөөтэй харьцуулвал 62%-ийн гүйцэтгэлтэй байна. /COVID-19/ цар тахлын нөлөөлөл харьцангуй буурч үйлдвэрийн газрын үйл ажиллагаа тогтворжиж ирлээ. Дараах хүснэгтэн мэдээллээр дэлгэрэнгүй харуулав.

2022 оны орлогын төлөвлөгөө, х/б/гүйцэтгэл 2 дугаар улирлын байдлаар

2022.06.30-ны байдлаар						/мян төг/
№	Орлогын төрөл	Жилийн төлөвлөгөө	2-р улирал			Жилийн хувь
			Төлөвлөгөө	ХБГүйцэтгэл	Хувь	
1	Техникийн хяналтын үзлэгийн орлого	13,530,665.9	8,530,129.96	8,143,708.0	95%	60%
1.1	Үзлэгийн орлого	13,490,665.9	8,512,630.0	8,097,528.0	95%	60%
1.2	Дүгнэлтийн орлого	40,000.0	17,500.0	46,180.0	264%	115%
2	Тээвэр зохицуулалтын орлого	6,213,269.0	3,257,408.2	3,536,524.5	109%	57%
2.1	Зөвшөөрлийн бичигний орлого	3,725,950.0	2,075,071.0	1,285,866.9	62%	35%
2.2	Маягт үнэт цаасны орлого (тооцооны, замын, м үнэмлэх)	40,000.0	18,989.4	25,900.1	136%	65%
2.3	Хот хоорондын тээврийн орлого	2,002,751.0	941,636.6	1,800,951.8	191%	90%
2.4	Улс хоорондын орлого			19,729.0		
2.5	Орон нутгийн тээврийн орлого	18,568.0	9,021.2	16,941.6	188%	91%
2.6	Ачаа тээшийн орлого	20,000.0	9,650.0	40,740.7	422%	204%
2.7	Мэргэшсэн жолоочын үнэмлэхний орлого	116,000.0	58,020.0	82,766.3	143%	71%
2.8	Мэргэшсэн жолоочын шалгалтын орлого	290,000.0	145,020.0	263,628.0	182%	91%
3	Хөдөлгөөний хяналт, удирдлагын	1,283,000.0	641,500.2	879,900.0	137%	69%
4	Бүртгэлийн үйлчилгээний орлого	4,900,000.0	2,461,206.7	3,534,263.3	144%	72%
5	Үйл ажиллагааны бусад орлого	250,000.0	123,917.7	145,562.0	117%	58%
5.1	Байрны түрээсийн орлого	150,000.0	74,945.5	51,795.7	69%	35%
5.2	Бусад орлого	100,000.0	48,972.2	93,766.3	191%	94%
Нийт дүн		26,176,934.9	15,014,162.7	16,239,957.8	108%	62%

Өсөлттэй орлогуудын шалтгаан:

Хот хооронд болон улс хоорондын зочигч тээвэр: Он гарсаар зорчигч тээвэрлэлтэд мөрдөн ажиллаж байсан түр тушаалыг цуцалсанаар зорчигч урсгал огцом нэмэгдэж орлого өсөлттэй харагдаж байна. Хот хоорондын орлогын жилийн төлөвлөгөөний 90 орчим хувь нь биелсэн. Мөн улс хоорондын орлогыг энэ онд төлөвлөөгүй ба улс хоорондын зорчигч урсгалыг нээснээр орлого төвлөрч эхэлсэн.

Ачаа тээврийн орлогын хувьд: үйлдвэрийн газар нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос ачаа тээшийн илгээмж, хадгалалт, хамгаалалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан ба хамтран ажиллах гэрээ байгуулсаны үндсэн дээр уг үйл ажиллагааг автобуудалтай орон нутаг салбар, төвүүдэд үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэл хүргүүлж ажилласан ба уг үйл ажиллагааны үндсэн дээр орлогын төлөвлөгөө өссөн.

Мэргэшсэн жолоочийн шалгалтын болон үнэмлэхний орлого: 2022 оны эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр 29635 хүн шалгалт өгч, мэргэшсэн жолоочийн үнэмлэх 7431 ширхэг хэвлэгдэж мэргэшсэн жолоочийн эрт хэрэгцээ нэмэгдсэн байна.

Бүртгэлийн үйлчилгээний орлого: Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсээс эхний хагас жилд улсын дугаарын дуудлага худалдааг зохион байгуулж нийт 600 ширхэг дугаарыг борлуулж бүртгэсэн байна.

Бусад орлого: өссөн шалтгаан нь мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкуудад хугацаатай хадгаламжаар байршуулан хүүгийн орлогыг нэмэгдүүлсэн.

Орлогыг сүүлийн 3 жилээр харьцуулан харахад өнгөрсөн оны мөн үед цар тахалын нөлөөлөл хэт их байснаас орлого бага байсан бол энэ оны орлого 35%-иар өссөн байна.

2020, 2021, 2022 оны 2 дугаар улирлын орлогын гүйцэтгэлийн харьцуулалт /төрлөөр/						
2022.06.30-ны байдлаар						/мян.төг/
	Орлогын төрөл	2020 оны 2 -р улирлын гүйцэтгэл	2021 оны 2 -р улирлын гүйцэтгэл	2022 оны 2 -р улирлын хбгүйцэтгэл	Харьцуулалт /Зөрүү/	
					2022 ХБГүйц /2021 гүйц	2022 ХБГүйц-2021 гүйц
1	Техникийн хяналтын үзлэгийн орлого	8,661,232.3	7,220,737.0	8,143,708.0	113%	922,971.0
2	Зөвшөөрлийн бичигний орлого	1,835,538.0	1,309,121.0	1,285,866.9	98%	(23,254.1)
3	Маягт үнэт цаасны орлого	13,651.9	16,167.0	25,900.1	160%	9,733.0
4	Хот хоорондын тээврийн орлого 4.8%	1,593,287.0	149,509.8	1,800,951.8	1205%	1,651,442.0
5	Улс хоорондын орлого 10%	30,867.5		19,729.0		19,729.0
7	Орон нутгийн тээврийн орлого	49,003.3	7,208.7	16,941.6	235%	9,732.9
8	Хөдөлгөөн хяналт удирдлагын орлого	471,041.1	620,080.2	879,900.0	142%	259,819.8
9	Түрээсийн орлого	82,475.6	83,345.9	51,795.7	62%	(31,550.3)
10	Бүртгэлийн орлого	633,480.9	2,397,792.1	3,534,263.3	147%	1,136,471.2
11	Мэргэшсэн жолоочийн үнэмлэхний орлого	28,545.5	53,295.5	82,766.3	155%	29,470.8
12	Мэргэшсэн жолоочын шалгалтын орлого	55,044.3	115,454.5	263,628.0	228%	148,173.5
14	Ачаа тээхийн орлого	20,038.9	5,395.4	40,740.7	755%	35,345.3
15	Бусад орлого	76,888.2	10,615.7	93,766.3	883%	83,150.6
	Нийт дүн	13,551,094.5	11,988,723.0	16,239,957.8	135%	4,251,234.8

Зардал: 2022 оны эхний хагас жилийн байдлаар зардалд 10.3 тэрбум төгрөгийг зарцуулж 43%-ийн гүйцэтгэлтэй хэтэрсэн зардалгүй ажиллаж байна.

2022 оны зардлын төлөвлөгөө,ХБГүйцэтгэл 2-р улирлын байдлаар

2022.06.30-ны байдлаар				/мян.төг/
Эдийн засгийн ангилал	Жилийн төлөвлөгөө	ХБГүйцэтгэл	Хувь	
Нийт зардал	24,053,376.8	10,372,588.6	43%	
Үйл ажиллагааны зардал	21,401,857.9	9,132,318.6	43%	
1. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	13,603,318.7	5,900,514.6	43%	
2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,062,014.4	868,316.2	42%	
3. Байгууллагын тогтмол зардал	1,691,234.53	970,795.97	57%	
4. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	589,000.0	251,468.5	43%	
5. Эд хогшлын зардал	369,000.0	133,114.4	36%	
6. Томилолт, зочны зардал сургалт	455,000.0	229,750.7	50%	
7. Бусад бараа үйлчилгээний зардал	2,632,290.24	778,358.29	30%	
8. Элэгдлийн зардал	2,651,518.9	1,240,270.0	47%	

Монгол Улсын Засгийн 2021.12.22-ны өдрийн 388 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2021.12.23-ны өдрийн 675 дугаар тогтоол, 2022.04.29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Төрийн хэмнэлтийн тухай хууль, ТӨБЗГ-аас 2022.05.18-ны өдрийн А-1/997 дугаар чиглэл хүргүүлэх тухай албан бичиг дээрх бүгд хууль, тогтоомж, тушаал шийдвэрийн дагуу хэмнэлтийн горимд шилжин, мөн хэмнэлтийн төлөвлөгөөг боловсруулан харъяа дээд шатны байгууллагуудад хүргүүлэн биелэлтийг ханган ажиллаж байна.

Улс орны эдийн засгийн хүндрэл үүссэн энэ үед бид хэмнэж болох зардлуудыг хэмнэн, байгууллагын ажиллагсдад олгодог үр дүнгийн урамшуулал болон тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зардал, хэмнэлтийн хуулиар заасан тодорхой зардлуудыг тус тус хэмнэсэн. Мөн ажиллагсдын эрүүл мэнд, цалин хөлс, цахилгаан дулаан, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардлыг санхүүжүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна. Үйлдвэрийн газар нь байр талбайг түрээслэн хамтран ажилладаг байгууллагуудад хөнгөлөлт үзүүлэх талаар хүсэлт

хүргүүлсэн үүний дагуу Таванган, Дахүрээ зэрэг аж ахуйн нэгжүүдээс он дуустал нийт 13.9 сая төгрөг, мөн тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг явуулдаг “Уранган” ХХК-ийн түрээсийн гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлсэний дагуу түрээсийн зардлаас нийтдээ 22.4 сая төгрөгийн хэмнэлт үүссэн. Мөн том оврын жип автомашинуудыг хот дотор ашиглахыг зогсоосон ба үүнээс сард 2.8 сая, жилд 34.2 сая төгрөгийн хэмнэлт үүссэн. Тээврийн хэрэгслүүдийг хэмнэлтийн горимд шилжиж зогсоосон тул сэлбэг хэрэгслийн зардлаас хэмнэхээр байна. Гадаад томилолт, бизнес уулзалт, гадаад сургалтын зардлуудыг хэмнэхээр төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажилласан.

2022 оны 2-р улирлын орлогын төлөвлөгөө, ХБГүйцэтгэл, ашиг алдагдал /салбараар/

2022.06.30-ны байдлаар								/мян.төг/
Салбар	ОРЛОГО /2-р улирлын байдлаар/			ЗАРДАЛ /2-р улирлын байдлаар/			Ашиг, алдагдал	
	Төлөвлөгөө	ХБГүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	ХБГүйцэтгэл	Хувь		
1	АРХАНГАЙ	293,826.0	345,889.1	118%	264,297.3	273,555.2	104%	72,334.0
2	БАЯН - ӨЛГИЙ	288,473.6	306,710.5	106%	291,702.1	220,332.0	76%	86,378.54
3	БУЛГАН	244,330.0	290,620.6	119%	134,257.9	180,479.2	134%	110,141.48
4	БАЯНХОНГОР	244,088.0	308,391.6	126%	291,767.6	277,813.0	95%	30,578.67
5	ГОВЬ - АЛТАЙ	198,670.0	246,370.1	124%	158,034.8	173,938.3	110%	72,431.81
6	ГОВЬ - СУМБЭР	106,887.9	241,075.1	226%	84,927.9	129,425.2	152%	111,649.95
7	ДАРХАН	357,993.4	436,445.5	122%	315,714.6	380,026.1	120%	56,419.46
8	ДОРНОГОВЬ	221,019.5	304,170.5	138%	198,286.1	219,011.6	110%	85,158.86
9	ДУНДГОВЬ	151,850.0	226,154.4	149%	128,053.4	145,330.1	113%	80,824.27
10	ДОРНОД	150,700.0	239,757.5	159%	196,739.2	202,984.4	103%	36,773.15
11	ЗАВХАН	218,607.5	301,554.9	138%	210,920.1	204,648.2	97%	96,906.69
12	ОРХОН	311,794.0	389,784.8	125%	245,650.1	245,848.7	100%	143,936.19
13	ӨВӨРХАНГАЙ	163,647.9	303,783.9	186%	193,492.3	217,499.2	112%	86,284.72
14	ӨМНӨГОВЬ	1,062,560.0	628,302.8	59%	310,659.8	281,580.0	91%	346,722.80
15	СҮХБААТАР	272,587.9	228,644.5	84%	176,355.9	195,971.0	111%	32,673.46
16	СЭЛЭНГЭ	456,958.0	484,074.3	106%	194,635.3	230,594.2	118%	253,480.18
17	ТӨВ	253,847.0	331,369.1	131%	192,596.6	221,459.2	115%	109,909.86
18	УВС	257,688.6	368,756.0	143%	215,205.7	243,673.9	113%	125,082.02
19	ХОВД	468,940.2	561,474.7	120%	200,700.9	201,646.7	100%	359,828.00
20	ХӨВСГӨЛ	399,381.7	390,123.6	98%	235,571.9	276,246.8	117%	113,876.80
21	ХЭНТИЙ	181,673.0	253,792.5	140%	193,170.1	192,259.7	100%	61,532.80
22	ЗАМЫН-ҮҮД	265,715.4	171,774.9	65%	276,918.3	276,583.4	100%	(104,808.53)
23	СХТХҮТ	1,171,926.0	933,674.4	80%	378,639.7	380,726.1	101%	552,948.37
24	СХЗТТ	477,500.0	1,199,243.2	251%	514,060.3	441,526.1	86%	757,717.10
25	БГТХҮТ	1,198,563.5	721,205.0	60%	411,190.3	346,912.5	84%	374,292.43
26	БЗЗТТ	72,000.0	153,639.9	213%	341,737.6	258,345.8	76%	(104,705.86)
27	БЗТХҮТ	1,349,024.0	994,117.8	74%	370,072.7	354,072.9	96%	640,044.86
28	ЦОГТЦЭЦИЙ	1,399,925.2	1,087,117.0	78%	169,339.1	183,849.9	109%	903,267.13
29	ТӨВ АЛБА	2,773,984.5	3,791,939.7	137%	5,213,690.1	3,416,249.7	66%	375,690.07
	Дүн	15,014,162.7	16,239,957.8	108%	12,108,387.5	10,372,588.6	86%	5,867,369.2

Ашиг алдагдал: Үйлдвэрийн газар нь 2022 оны 2-р улирлын байдлаар төсвийн төлбөрт нийт 2.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Үүнд татварын байгууллагад 1.3 тэрбум төгрөг, НДШ 868.3 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамжид 680.9 сая төгрөг тус тус төлж 4.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллана.

ДҮГНЭЛТ

“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар нь автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, улс, хот хооронд, орон нутгийн нийтийн зорчигч болон ачаа тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг улсын хэмжээнд зохицуулах, зохион байгуулах, автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох, авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох, автотээврийн салбарын бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалт олгох ажлуудыг дүрмэнд заасны дагуу эрхлэн явуулж, 2022 оны 1 дүгээр улиралд дараахь ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Үйлдвэрийн газар нь 2022 оны эхний хагас жилд нийт 15.0 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллахаар төлөвлөснөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 16.2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж 108%-ийн биелэлттэй ажиллалаа.

2022.06.20-ны өдрийн байдлаар **394549** тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамруулахаар төлөвлөснөөс **335197** тээврийн хэрэгсэл буюу **85.1** %-ийн гүйцэтгэлтэй техникийн хяналтын үзлэгийг улсын хэмжээнд зохион байгуулан ажилласан.

Үйлдвэрийн газар нь 2022.06.20-ны байдлаар улсын хэмжээнд **43840** тээврийн хэрэгслийг шинээр бүртгэсэн нь 2021 оны мөн үеийнхээс **11564** тээврийн хэрэгсэл буюу **20%**-иар буурсан дүнтэй байна.

Хот хоорондын чиглэлд 2022 оны эхний хагас жилийн байдлаар **599,4** мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс **87,6%**-аар өссөн байна.

Тайлант хугацаанд үйлдвэрийн газар нь 16,979 жолоочоос давхардсан тоогоор 29,292 удаа шалгалт авч 13,249 жолооч шалгалт тэнцсэнээс 7,357 мэргэшсэн жолоочийн үнэмлэх хэвлэж олгосон.

Автозамаар экспортын голлох бүтээгдэхүүнүүд болох нүүрс 6,0 сая.тн төмрийн хүдэр 25873 тн, зэсийн баяжмал 226760 тн тус тус тээвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд 12 иргэн, аж ахуй нэгж байгууллагын үйлчилгээнд баталгаажуулалтын үнэлгээг хийсэн бөгөөд нийт 16 иргэн, ААНБ-д тохирлын гэрчилгээ олгосон байна. Мөн Лаборатори нь автотээврийн салбарт ашиглагдаж байгаа 9 төрлийн 108 ширхэг хэмжих хэрэгсэлд олон улсын нэгжийн СИ системийн дагуу нэгж дамжуулах, шалгалт, тохируулга хийж гэрчилгээ олгосон байна.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь 2022 оны эхний хагас жилд дараахь томоохон ажлуудыг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

1. Техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх ажлын хүрээнд “Удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулж баталсан бөгөөд тус хөтөлбөрийн агуулгын дагуу “Нөөцөд дүн шинжилгээ хийх заавар”, “Сургалт зохион байгуулж, чадавхижуулах заавар”, “Үйл ажиллагааг баталгаажуулах заавар”-уудыг тус тус боловсруулж, баталлаа.
2. Х59 дугаартай “Улаанбаатар хот–Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум” чиглэлийн үйлчилгээг 2022.03.02-ний өдрөөс, ХХ57 дугаартай “Улаанбаатар хот – Сэлэнгэ аймгийн Ерөө сум” чиглэлийн үйлчилгээг 2022.04.01-ний өдрөөс тус тус эхлүүлсэн.
3. Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийхэд шаардлагатай сервис солилцох тоон гарын үсгээр баталгаажсан албан хүсэлтийг хүлээн авч, гэрчилгээний төлбөрийг цахимаар гүйцэтгэх боломжийг бүрдүүллээ. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн VRS систем дээр цахим хүсэлтийн хөгжүүлэлтийг бүрэн хийж дуусгав.
4. Цахим монгол хөтөлбөрийн хүрээнд ЗТХЯ, Нотариатчдын танхим хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээний хүрээнд нотариатын серверийг бүртгэлийн програмтай холбон үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

5. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дуудлага худалдааг тасралтгүй амжилттай зохион байгуулан явуулсан бөгөөд 2022 оны эхний хагас жилд Хүүхдийн төлөө санд 1,5 тэрбум төгрөг төвлөрүүлсэн бөгөөд дуудлага худалдаа зохион байгуулж эхэлснээс хойш Хүүхдийн төлөө санд нийт 5 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.
6. Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах зорилгоор тайлант хугацаанд Нийслэлийн Хан-уул дүүргийн нутаг дэвсгэрт Яармаг, Зайсан салбарыг шинээр нээн ажиллуулж байгаа бөгөөд Да хүрээ, Олон улсын авто худалдааны цогцолборт байрлах салбарын ажлын цагийг уртасган Хөдөлмөрийн хууль, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд зохицуулалт хийн ажиллаж байна.
7. Жуулчин тээврийн үйлчилгээ төрийн цахим үйлчилгээний <http://e-mongolia.mn> системд нэгдсэнтэй холбоотой төрийн цахим үйлчилгээний <http://e-mongolia.mn> системээр дамжуулан жуулчин таних тэмдэг / TOURIST/ авах хүсэлтүүдийг авч эхлээд байна.
8. Дотоодын ачаа тээврийн <https://logistic.transdep.mn/> сайтны мобайл гар утасны аппликейшнийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан бэлэн болгож, 2022.03.31-ны өдөр андройд гар утсанд зориулагдсан хувилбарыг Playstore-д байршуулсан.
9. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/200 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах, тээвэрлэлийн ажил үйлчилгээг сайжруулах, зорчигч тээврийн автобуудлаар тав тухтай, соёлтой үйлчлүүлэх боломжийг хангах, сайжруулах зорилгоор ачаа тээшийг “Бүртгэлжүүлэх, түр хадгалах” үйлчилгээг олон нийтэд хүргэх зорилт тавин Баянхонгор, Увс, Завхан, Өвөрхангай, Дорноговь, Дархан-Уул аймгууд автобуудлаар дамжуулан илгээмжийн ачааг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж байна.
10. Автотээврийн салбарын стандартчиллын Техникийн хороо /ТХ-15/-ны 2022.03.04-ний өдрийн хуралдаанаар MNS ...-2022 Тээврийн хэрэгслийн резин дугуй засварын үйлчилгээ. Ерөнхий шаардлага, MNS ...-2022 Автотээврийн хэрэгслийн их биеийн засвар, үйлчилгээний байгууллагад тавих шаардлага, MNS ...-2022 Автотээврийн хэрэгслийг тос, тослогооны болон ашиглалтын материалаар цэнэглэх үйлчилгээ. Ерөнхий шаардлага. гэсэн 3 стандартыг хэлэлцүүлж батлуулсан.
11. Тус үйлдвэрийн газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч нар 2022 оны эхний хагас жилийн байдлаар Зорчигч тээврийн 7361, ачаа тээврийн 3587, тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч тээврийн 165 тээврийн хэрэгслүүдийг шалгаж, нийт 776 зөрчилд 85.750.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулж 9054 иргэнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан байна.
12. Үйлдвэрийн газрын архивт байнга хадгалах хугацаа дууссан 2009-2013 оны 83 хадгаламжийн нэгжийг батлагдсан данс бүртгэлийн дагуу Үндэсний төв архивт шилжүүлэн өгч байнга хадгалах баримтыг төв архивт шилжүүлэн өгдөг хөмрөг үүсгэгч байгууллагаар бүртгүүлсэн.

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ